



БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН **2022**

2023 он



АГУУЛГА

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛ	3
НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ХОЁР. “БЗӨБЦТС” ТӨХК-ИЙН 2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ.....	4
2.1. Зорилт: 1.1,1.3 Худалдан авсан цахилгаан эрчим хүч	4
2.2. Зорилт: 1.2,1.4 Цахилгаан эрчим хүч түгээлтийн алдагдал	5
2.3. Зорилт:1.5 Борлуулсан цэх.....	5
2.4. Зорилт: 2 Нийт орлого	6
2.5. Зорилт:3 Нийт зардал	8
2.6. Зорилт:4-5 Татвар төлөхийн өмнөх, дараахь ашиг, алдагдал	11
2.7. Зорилт:6 Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал.....	12
2.8. Зорилт:7 Нийт авлага.....	12
2.9. Зорилт:8 Нийт нийт өр төлбөр.....	13
2.10. Зорилт: 9 Нийт ажиллагсдын тоо	13
2.11. Зорилт: 10 Нийт цалингийн сан.....	14
2.12. Зорилт: 11 Нэг ажилтны дундаж цалин	14
2.13. Зорилт: 12 Цахилгааны тасалдлын дундаж хугацаа (и-сайди)	14
2.14. Зорилт: 13 Их засвар, тзбах, хөрөнгө оруулалт	14
ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР	15
3.1. Хүний нөөцийн удирдлага	15
3.2. Хүний нөөцийн судалгаа.....	16
3.3. Шүүхийн маргаан, хөдөлмөрийн харилцаа	19
3.4. Албан хэрэг хөтлөлт, архив бичиг хэргийн ажилд хийсэн хяналт шалгалт, тооллогын ажлын үр дүн, бүртгэл, хөтлөлтийн талаар хийсэн ажил:	19
3.5. Сургалтын чиглэлээр	21
ДӨРӨВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР	25
4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөө, гүйцэтгэл	25
4.2. Осол зөрчлийн судалгаа, урьдчилан сэргийлэхээр хийсэн ажил	25
4.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ээлжит үзлэг, шалгалт.....	27
ТАВ. ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖЛУУД.....	29
5.1. Техникийн нөхцөл олголтын талаар:	29
5.2. Төсөв, судалгаа, төлөвлөлтийн ажлын талаар:	31
5.3. Их засвар, ТЗБАХ-ний болон хөрөнгө оруулалтын ажлын чиглэлээр	31
5.4. Цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангах	39



5.5. Урсгал засварын ажлын талаар	40
5.6. Үр өгөөжийн тооцоо.....	43
5.7. Горим стандартчиллын талаар	45
ЗУРГАА.ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	60
6.1. Худалдан авсан цахилгаан эрчим хүч	60
6.2. Борлуулсан цахилгаан эрчим хүч	60
6.3. Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдал.....	60
6.4. Цахилгаан эрчим хүчний авлага:	61
6.5. Хэрэглээний бүтэц	62
6.6. Хэрэглэгчдийн тоо.....	62
6.7. Хэрэглэгчдээс ирсэн санал хүсэлтийг шийдвэрлэсэн байдал:	63
ДОЛОО.ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, ГОРИМЫН ЧИГЛЭЛЭЭР	64
7.1. Тасралтын талаар	64
7.2. Шинэ хэрэглэгчийн судалгаа	65
7.3. Захиалгат ажлын судалгааны талаар.....	67
НАЙМ.ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР	69
8.1. Худалдан авалтын төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт.....	69
ЕС. “ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСӨЛ-2”-ЫН ХҮРЭЭНД	72
АРАВ. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР.....	81
10.1. Программ хангамжийн хүрээнд:	81
10.2. Техник хангамжийн хүрээнд:	83
10.3. Хэрэглэгчдэд үйлчлэх ажлын хүрээнд:.....	89
10.4. Мэдээллийн аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтын ажлын хүрээнд:	
90	



“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛ

АЛСЫН ХАРАА

Бид дэлхийн жишигт хүрнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын зүүн өмнөд бүсийн хөгжлийн хөтлөгч нь байж хэрэглэгчдэд чанартай цахилгаан эрчим хүчийг тасралтгүй ханган түгээгч, хэрэглэгч, хамт олноо дээдэлсэн тэргүүлэх компани байх болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Хэрэглэгчдээ дээдлэх
- Хуулийн хүрээнд ажиллах чадвар
- Ил тод шударга байдал
- Чанар хариуцлага
- Сахилга бат
- Мэргэжлийн ур чадвартай, бүтээлч байх
- Хуримтлуулсан ажлын туршлага

НЭГ. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Бүгд найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 1984 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 328 дугаар тогтоолоор “БАГАНУУР ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР” нэртэйгээр байгуулагдсан.

Монгол Улсын Их Хурлаас 2001 онд шинэчлэн баталсан Эрчим хүчний тухай хуулийн хэрэгжилтийг хангах Засгийн газрын 164 дүгээр тогтоолын дагуу тус газар нь “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК болж бүтэц, зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөн, ашиглалт үйлчилгээний заагаар хойд тал нь Хэнтий аймгийн Дадал сумаас урд тал нь Дорноговь аймгийн Замын-Үүд сум хүртэл, зүүн тал нь Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас, баруун тал нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сум хүртэл, нийслэлийн Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудын төв, 7 аймгийн 53 сум, суурин газрын нутаг дэвсгэрт байрлах 52.3 мянга гаруй хэрэглэгчийг 6 хэлтэс, 6 алба, 1 нэгж, 5 салбар, 548 ажилтантайгаар цахилгаан түгээх, цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах, түгээх тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явууллаа.

Тус компани нь 2022 оны гүйцэтгэлээр 519 сая кВт*цаг цахилгаан эрчим хүчийг “Диспетчерийн Үндэсний Төв” ХХК-иас худалдан авч, 475 кВт*цаг цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээн борлуулж, 6-35кВ-ын хүчдэлтэй 496 дэд өртөө, 4570.9км урттай 0.4-35кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугамын ашиглалт засвар үйлчилгээ, хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.



**ХОЁР. “БЗӨБЦТС” ТӨХК-ИЙН 2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,
ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ**

Эрчим хүчний сайдын 2022 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/205 дугаар тушаал, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 20 дугаар тогтоолоор тус тус шинэчлэн баталсан компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний 13 үзүүлэлтүүдээс 12 үзүүлэлтийг хангаж, 92.3 хувиар биелүүлж ажилласан. (Хүснэгтээр)

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 он гүйц	2022 он төлөв	2022 он гүйц	Өөрчлөлт			
						өмнөх оноос		төлөв-нөөс	
						дүн	хувь	дүн	хувь
1	2	3	4	5	6	10	11	12	13
1	1.1 Худалдан авсан цахилгаан	сая кВт*ц	506.1	488.6	518.6	12.5	102.5%	30.0	106.1%
	ДҮТ ТӨХХК-иас	сая кВт*ц	505.3	487.1	517.0	11.7	102.3%	29.9	106.1%
	Импорт	сая кВт*ц	0.8	1.5	1.6	0.8	208.4%	0.1	106.3%
	1.2 Түгээлтийн нийт алдагдал	хувиар	6.29%	8.26%	8.18%	1.89%	130.0%	-0.08%	99.0%
	хувиар	хувь	31.8	40.4	42.4	10.6	133.2%	2.1	105.1%
	биетээр	сая кВт*ц	6.28%	8.24%	8.16%	1.88%	129.9%	-0.08%	99.0%
	ДҮТ ТӨХХК	сая кВт*ц	31.8	40.1	42.2	10.4	132.9%	2.1	105.1%
	хувиар	хувь	11.05%	14.50%	13.66%	2.62%	123.7%	-0.83%	94.3%
	биетээр	сая кВт*ц	0.1	0.2	0.2	0.1	257.8%	0.0	102.2%
	1.3 Борлуулсан ЦЭХ	сая кВт*ц	474.2	448.3	476.2	2.0	100.4%	27.9	106.2%
	үүнээс: ДҮТ ТӨХХК	сая кВт*ц	473.5	447.0	474.8	1.3	100.3%	27.8	106.2%
	Импорт	сая кВт*ц	0.7	1.3	1.4	0.7	202.3%	0.1	107.4%
	Борлуулалтын дундаж үнэ	төг/кВт*ц	182.08	184.47	188.94	6.86	103.8%	4.47	102.4%
2	Нийт орлого	сая төг	110,985.2	105,065.2	112,930.9	1,945.7	101.8%	7,865.7	107.5%
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	86,222.6	82,459.6	89,710.1	3,487.5	104.0%	7,250.6	108.8%
	Түгээх үйлчилгээний орлого	сая төг	22,127.3	21,595.3	21,595.3	(532.0)	97.6%	(0.0)	100.0%
	Импортын ЦЭХ-ний орлого	сая төг	160.0	343.5	339.6	179.6	212.3%	(4.0)	98.8%
	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	2,475.4	666.8	1,285.9	(1,189.5)	51.9%	619.1	192.8%
3	Нийт зардал	сая төг	110,933.8	109,528.3	118,754.0	7,820.1	107.0%	9,225.7	108.4%
	Үүнээс: ХАЦЭХ-ний өртөг	сая төг	83,921.9	78,680.8	86,672.0	2,750.1	103.3%	7,991.1	110.2%
	ХАЦЭХ-ний тариф	төг/кВт*ц	166.08	161.52	167.64	1.56	100.9%	6.13	103.8%
	Хангах, түгээх үйл ажиллагааны зардал	сая төг	24,855.4	26,753.3	26,379.5	1,524.1	106.1%	(373.7)	-1.40%
	Импортын эрчим хүчний зардал	сая төг	183.2	324.3	389.1	205.9	212.3%	64.8	120.0%
	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	1,973.3	3,769.8	5,313.4	3,340.1	269.3%	1,543.6	140.9%
ҮХЭ-ийн зардал	сая төг	7,533.6	7,865.8	7,658.3	124.7	101.7%	(207.5)	97.4%	
4	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	сая төг	51.4	(4,463.0)	(5,823.0)	5,874.5	-11326.7%	1,360.0	130.5%
	Үндсэн үйл ажиллагааны ашиг, алдагдал	сая төг	(427.4)	(1,379.3)	(1,746.1)	1,318.7	408.5%	366.8	126.6%
	Импортын эрчим хүчний ашиг, алдагдал	сая төг	(23.3)	19.2	(49.5)	26.2	212.6%	68.7	-257.5%
	Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал	сая төг	502.1	(3,103.0)	(4,027.4)	4,529.6	-802.1%	924.4	129.8%
	Орлогын албан татвар	сая төг	673.1	(151.4)	(151.4)	(824.5)	-22.5%	(151.4)	0.0%
5	Татварын дараахь ашиг, алдагдал	сая төг	(621.7)	(4,463.0)	(5,671.7)	5,050.0	912.3%	1,208.6	127.1%
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.00	1.04	1.05	0.05	105.2%	0.01	100.9%
7	Нийт авлага	сая төг	4,929.9	1,814.7	2,887.6	(2,042.3)	58.6%	1,072.9	159.1%
	Үүнээс: Хэрэглэгчээс авах ЦЭХ-ний авлага	сая төг	998.7	1,425.0	2,681.1	1,682.4	268.5%	1,256.1	188.1%
	Засгийн газрын хөнгөлөлт авлага	сая төг	2,220.3	-	-	(2,220.3)	0.0%	-	0.0%
	Шөнийн тарифын авлага	сая төг	245.4	352.9	89.0	(156.4)	36.3%	(263.9)	25.2%
	НХА-аас авах авлага	сая төг	445.4	-	-	(445.4)	0.0%	-	0.0%
	ААНОАТ авлага	сая төг	382.4	-	-	(382.4)	0.0%	-	0.0%
	Бусад авлага	сая төг	637.8	36.8	117.5	(520.3)	18.4%	80.7	319.1%
8	Нийт өр төлбөр	сая төг	15,192.8	35,524.7	36,064.7	20,871.9	237.4%	540.0	101.5%
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	14,857.2	33,266.5	35,031.6	20,174.5	235.8%	1,765.1	105.3%
	Богино хугацаат өр төлбөр	сая төг	335.7	2,258.2	1,033.1	697.4	307.8%	(1,225.2)	45.7%
	Үүнээс: НХА-ийн өглөг	сая төг	-	1,920.6	-	-	0.0%	(1,920.6)	0.0%
	ЦЭХ-ний УТГ	сая төг	335.7	337.6	276.6	(59.1)	82.4%	(61.0)	81.9%
	ААНОАТ өглөг	сая төг	-	-	344.9	344.9	0.0%	344.9	0.0%
	НӨАТ өглөг	сая төг	-	-	112.8	112.8	0.0%	112.8	0.0%
Бусад өглөг	сая төг	328.8	-	298.7	(30.1)	90.9%	298.7	0.0%	
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	552	554	548	(5)	99.2%	(7)	98.8%
10	Нийт цалингийн сан	сая төг	11,256.9	12,265.1	12,125.3	868.4	107.7%	(139.8)	98.9%
11	Нэг ажилтны дундаж цалин /сарын/	төгрөг	1,699,410	1,844,931	1,845,553	146,143.3	108.6%	622.2	100.0%
12	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа Исайди	минут	759.0	765.1	734.7	(24.3)	96.8%	(30.4)	96.0%
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая төг	3,574.3	5,896.0	4,742.3	1,168.0	132.7%	(1,153.7)	80.4%
	Үүнээс: Хөрөнгө оруулалт	сая төг	636.3	2,765.3	1,985.9	1,349.6	312.1%	(779.4)	71.8%
	Их засвар	сая төг	446.6	832.3	760.5	313.9	170.3%	(71.8)	91.4%
	ТЗБАХ	сая төг	2,491.4	2,298.3	1,995.9	(495.5)	80.1%	(302.4)	86.8%

2.1. Зорилт: 1.1.1.3 Худалдан авсан цахилгаан эрчим хүч

2022 онд нийт 518.6 сая кВт*ц цахилгаан эрчим хүчийг худалдан авч, үүнээс “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-иас нийт 517.0 сая кВт*ц цахилгаан эрчим хүчийг, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомтоор 1.6 сая кВт*ц цахилгаан

“БЗӨБЦТС ТӨХК”-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



эрчим хүчийг импортоор тус тус худалдан авч, төлөвлөгөөг 30.1 сая кВт*ц-аар илүү буюу 106.1 хувиар биелүүлж ажилласан. (Хүснэгтээр)

Үзүүлэлт	Худалдан авсан ЦЭХ				Борлуулсан ЦЭХ			
	Зорилт	Гүйц	дүн	хувь	Зорилт	Гүйц	дүн	хувь
“ДҮТ” ТӨХХК	487.1	517.0	29.9	106.1%	447.0	474.8	27.8	106.2%
Импорт ЦЭХ	1.5	1.6	0.3	119.6%	1.3	1.4	0.1	107.4%
Нийт дүн	488.6	518.6	30.0	106.1%	448.3	476.2	27.9	106.2%

Салбар тус бүрээр:

Үзүүлэлт	Нийт дүн	Багануур	Дорно-говь	Дундговь	Хэнтий	Говь-сүмбэр
Төлөвлөгөө	487.1	77.7	100.1	41.6	56.4	211.3
Гүйцэтгэл	517.0	81.5	104.7	46.9	63.6	220.3
өөрчлөлт /+/-/	29.9	3.8	4.6	5.3	7.2	9.0
өөрчлөлт /%-иар/	106.1%	104.9%	104.6%	112.8%	112.7%	104.3%

2.2. Зорилт: 1.2.1.4 Цахилгаан эрчим хүч түгээлтийн алдагдал

Нийт худалдан авсан цахилгаан эрчим хүчний 8.18 хувийг буюу 42.4 сая кВт*ц-ийг түгээлтийн алдагдалд тооцож, төлөвлөгөөнөөс 0.08 нэгжээр буурсан.

- “ДҮТ” ТӨХХК-иас худалдан авсан ЦЭХ-ний түгээлтийн алдагдал 8.16 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөнөөс 0.08 нэгжээр,
- Импортын ЦЭХ-ний түгээлтийн алдагдал 13.66 хувийн гүйцэтгэлтэй, төлөвлөгөөнөөс 0.83 нэгжээр тус тус буурсан. (Хүснэгтээр)

д/д	Үзүүлэлт	Нийт дүн	Багануур	Дорноговь	Дундговь	Хэнтий	Говь-сүмбэр
1	Төлөвлөгөө	8.24%	10.29%	8.59%	15.18%	16.06%	3.86%
2	Гүйцэтгэл	8.16%	9.94%	8.59%	14.88%	15.90%	3.63%
3	өөрчлөлт /+/-/	-0.08%	-0.35%	0.00%	-0.30%	-0.16%	-0.23%

2.3. Зорилт:1.5 Борлуулсан цэх

Нийт 476.2 сая кВт*ц цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд борлуулж, үүнээс төвийн бүсийн хэрэглэгчдэд 474.8 сая кВт*ц -ийг, Ханги хилийн боомтын хэрэглэгчдэд 1.4 сая кВт*ц-ийг тус тус борлуулж, төлөвлөгөөг 27.9 сая кВт*ц-аар илүү буюу 106.2%-иар тус тус биелүүлж ажилласан. (Хүснэгтээр)

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 он гүйц	2022 он төлөв	2022 он гүйц	Өөрчлөлт			
						өмнөх оноос		Төлөв-нөөс	
						дүн	хувь	дүн	хувь
	Борлуулсан ЦЭХ	сая кВт*ц	473.5	447.0	474.8	1.3	100.3%	27.8	106.2%
1	Уул уурхай	сая кВт*ц	177.1	148.3	164.2	(12.9)	92.7%	15.9	110.7%
	УААГ	сая кВт*ц	201.8	214.0	224.1	22.3	111.0%	10.1	104.7%
	Орон сууц	сая кВт*ц	36.7	32.0	32.4	(4.3)	88.2%	0.4	101.3%
	Гэр хороолол	сая кВт*ц	57.9	52.7	54.1	(3.8)	93.4%	1.4	102.6%



Салбар тус бүрээр:

(сая кВт*ц-аар)

д/д	Үзүүлэлт	Нийт дүн	Багануур	Дорно-говь	Дундговь	Хэнтий	Говь-сүмбэр
1	Төлөвлөгөө	447.0	69.7	91.5	35.3	47.4	203.2
2	Гүйцэтгэл	474.8	73.4	95.7	40.0	53.5	212.3
3	өөрчлөлт /+-/	27.8	3.7	4.2	4.7	6.1	9.2
4	өөрчлөлт /%-иар/	106.2%	105.3%	104.6%	113.2%	112.9%	104.5%

Борлуулалтын дундаж үнийн талаар.

Хэрэглэгчдэд борлуулсан 1 кВт*ц цахилгаан эрчим хүчний дундаж үнэ 188.94 төг/кВт*ц-ийн гүйцэтгэлтэй гарч, өнгөрсөн оны мөн үеэс 6.86 төг/кВт*ц-аар, төлөвлөгөөнөөс 4.46 төг/кВт*ц -аар тус тус өссөн байна. ЭХЗХ-ны Зохицуулагчдын зөвлөлийн 2022 оны 11-р сарын 30-ны өдрийн 4/1198 дугаар тогтоолоор 11 дүгээр сарын 22-ний өдрөөс эхлэн уул уурхай, ҮААГ-ийн 1 кВт*ц цахилгаан эрчим хүчний үнэ нэмэгдсэн. (Хүснэгтээр)

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 он гүйц	2022 он төлөв	2022 он гүйц	Өөрчлөлт			
						өмнөх оноос		Төлөв-нөөс	
						дүн	хувь	дүн	хувь
3	Борлуулалтын дундаж үнэ	төг/кВт*ц	182.08	184.48	188.94	6.86	103.8%	4.46	102.4%
	Уул уурхай	төг/ кВт*ц	212.82	219.87	227.86	15.04	107.1%	7.98	103.6%
	ҮААГ	төг/ кВт*ц	171.00	174.57	177.03	6.03	103.5%	2.46	101.4%
	Орон сууц	төг/ кВт*ц	149.72	148.99	148.28	(1.44)	99.0%	(0.71)	99.5%
	Гэр хороолол	төг/ кВт*ц	147.23	146.59	144.51	(2.72)	98.2%	(2.09)	98.6%

2.4. Зорилт: 2 Нийт орлого

Нийт 105,065.2 сая төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 112,930.9 сая төгрөгийн орлоготой, төлөвлөгөөнөөс 7,865.7 сая төгрөгөөр илүү буюу төлөвлөгөөг 107.5 хувиар биелүүлж ажилласан. Үүнд:

- ✚ ЦЭХ-ний борлуулалтын орлогын төлөвлөгөөг 7,250.6 сая төгрөгөөр илүү буюу 108.8 хувиар,
- ✚ Түгээх үйлчилгээний орлогын төлөвлөгөөг 100.0 хувиар,
- ✚ Импортын ЦЭХ-ний орлогын төлөвлөгөөг 4.0 сая төгрөгөөр дутуу буюу 98.8 хувиар,
- ✚ Үйл ажиллагааны бус орлогын төлөвлөгөөг 619.1 сая төгрөгөөр илүү буюу 192.8 хувиар тус тус биелүүлж ажилласан. (Хүснэгтээр)

(сая төг-өөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэт	дүн	хувь
1. ЦЭХ-ний борлуулалтын орлого	82,459.6	89,710.1	7,250.6	108.8%
2. Түгээх үйлчилгээний орлого	21,595.3	21,595.3	(0.0)	100.0%
3. Импортын ЦЭХ-ний орлого	343.5	339.6	(4.0)	98.8%
4. Үйл ажиллагааны бус орлого	666.8	1,285.9	619.1	192.8%
Нийт дүн	105,065.2	112,930.9	7,865.7	107.5%

“БЗӨБЦТС ТӨХК”-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Цэх-ний борлуулалтын орлого

Нийт **82,459.6** сая төгрөгийн ЦЭХ-ний орлоготой ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр **89,710.1** сая төгрөгийн орлоготой ажиллаж, уул уурхайн борлуулалтын орлого 4,802.7 сая төг-өөр, ҮААГ-ын борлуулалтын орлого 2,316.6 сая төг-өөр тус тус нэмэгдсэн нь борлуулалтын орлого 7,250.5 сая төг-өөр өсөхөд голлон нөлөөлсөн байна. (Хүснэгтээр)

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 он гүйц	2022 он төлөв	2022 он гүйц	Өөрчлөлт			
						өмнөх оноос		Төлөв-нөөс	
						дүн	хувь	дүн	хувь
	Борлуулалтын орлого	сая төг	86,222.6	82,459.6	89,710.1	3,487.5	104.0%	7,250.5	108.8%
	Уул уурхай	сая төг	37,681.7	32,610.6	37,413.3	(268.3)	99.3%	4,802.7	114.7%
2	ҮААГ	сая төг	34,510.5	37,357.7	39,674.3	5,163.7	115.0%	2,316.6	106.2%
	Орон сууц	сая төг	5,500.7	4,763.5	4,803.5	(697.1)	87.3%	40.0	100.8%
	Гэр хороолол	сая төг	8,529.7	7,727.8	7,819.0	(710.7)	91.7%	91.2	101.2%

Салбар тус бүрээр:

(сая төг-өөр)

д/д	Салбарууд	ЦЭХ-ний нийт орлого	Үүнээс; Чадлын тарифаар	Дэмжих тарифаар	Хөнгөлөлт (Засгийн газар, шөнийн тариф)	Чадлын итгэл-цүүр	Бор-тын орлогын дүнд эзлэх %
1	Багануур	13,549.1	1,489.4	1,697.7	997.9	75.5	31.4%
2	Дорноговь	17,533.5	1,638.3	2,216.5	1,449.6	272.2	31.8%
3	Дундговь	7,548.5	787.9	950.5	792.9	68.5	34.4%
4	Хэнтий	9,833.1	1,117.6	1,272.5	1,207.7	11.6	36.7%
5	Говьсүмбэр	41,245.9	4,548.5	5,008.8	936.3	326.8	26.2%
	Нийт дүн	89,710.1	9,581.6	11,146.0	5,384.3	754.6	29.9%

Түгээх үйлчилгээний орлого (төлбөр)

ЭХЗХ-ны Зохицуулагчдын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 98 дугаар тогтоолоор цахилгаан түгээх үйлчилгээний төлбөрийн орлогыг **21,595.3** сая төгрөгөөр баталсан.

Импортын эрчим хүчний борлуулалтын орлого

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомтын хэрэглэгчдэд нийт **1,588.5** мян.кВт*ц цахилгаан эрчим хүчийг дунджаар **247.76** төг/кВт*ц-аар хэрэглэгчдэд борлуулж, нийт **339.6** сая төгрөгийн борлуулалтын орлоготой, төлөвлөгөөнөөс **4.0** сая төгрөгөөр дутуу буюу 98.8 хувиар биелүүлсэн.

Үйл ажиллагааны бус орлого:

Нийт **666.8** сая төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр **1,285.9** сая төгрөгийн орлоготой, төлөвлөгөөнөөс **619.1** сая төгрөгөөр илүү буюу төлөвлөгөөг **192.8** хувиар биелүүлж ажилласан. Үүнээс:

- ✚ Борлуулалтын бусад орлого **330.0** сая төг-ийн,
- ✚ Үйл ажиллагааны бус орлого **955.9** сая төг-ийн,



(мян. төг-өөр)

д/д	Үзүүлэлт	2022 он 4-р улирал		төлөв-нөөс
		Төлөв	Гүйцэт	
1. Бусад орлого				
1	Алданги	2,610.0	16,708.5	14,098.5
2	Төлбөрт үйлчилгээ	70,610.0	157,842.5	87,232.5
3	Маягтны үнэ	11,419.6	8,649.5	(2,770.1)
4	Тоолуур тохируулгын орлого	16,976.5	22,199.2	5,222.7
5	Техникийн нөхцөл	58,200.0	124,595.5	66,395.5
Борлуулалтын бусад орлогын дүн		159,816.1	329,995.1	170,179.1
1	Тендерийн материалын орлого	6,000.0	5,523.6	(476.4)
2	Хүү, торгуулийн орлого	700.0	8,983.6	8,283.6
3	Найдваргүй авлагын нөөц	-	4,575.0	4,575.0
4	Материал борлуулсны орлого	28,254.6	39,156.6	10,902.0
5	Түрээсийн орлого	9,230.7	17,975.9	8,745.2
6	Цайны газрын түрээсийн орлого	2,400.0	200.0	(2,200.0)
7	Цайны газрын орлого	106,184.1	93,381.3	(12,802.8)
8	Үндсэн хөрөнгө борлуулсан орлого	18,695.0	38,395.3	19,700.3
9	Төлийн орлого	3,018.2	3,389.1	370.9
10	Ноос ноолуурын орлого	3,664.5	4,481.8	817.3
11	Мал борлуулсан орлого	6,518.0	11,088.5	4,570.5
12	Нас дэвшилт	5,541.8	5,830.0	288.2
13	МҮОНТ хураамжын орлого	60,833.0	79,848.5	19,015.5
14	Хог хаягдлын хураамжийн орлого	92,973.6	106,290.0	13,316.4
15	Бусад орлого, шалгалт	-	2,253.2	2,253.2
16	Гадаад валютын бодит ашиг	-	1,104.0	1,104.0
17	Барилга угсралт засвар үйлчил.	163,000.0	533,464.5	370,464.5
Үйл ажиллагааны бус орлогын дүн		507,013.5	955,941.0	448,927.5
НИЙТ ДҮН		666,829.6	1,285,936.2	619,106.6

2.5. Зорилт:3 Нийт зардал

Нийт **109,528.3** сая төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр **118,754.0** сая төгрөгийн зардалтай, төлөвлөгөөнөөс 9,225.7 сая төгрөгөөр буюу 8.4 хувиар хэтэрсэн. Үүнд:

- ✚ Худалдан авах ЦЭХ-ний зардал: нийт 86,672.0 сая төгрөгийн зардалтай, төлөвлөгөөнөөс 7,991.1 сая төгрөгөөр хэтэрсэн. Төлөвлөгөөнөөс 29.9 сая кВт*ц цахилгаан эрчим хүчийг илүү худалдан авсан, “ДҮТ” ТӨХХК-иас худалдан авах 1 кВт*ц цахилгаан эрчим хүчний тариф 6.13 төг/кВт*ц-аар нэмэгдсэн нь зардал хэтрэхэд нөлөөлсөн байна.
- ✚ Хангах, түгээх үйл ажиллагааны зардал: нийт 26,379.5 сая төгрөгийн зардалтай, төлөвлөгөөнөөс 373.7 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар хэмнэсэн.
- ✚ Үйл ажиллагааны бус зардал: нийт 5,313.4 сая төгрөгийн зардалтай, төлөвлөгөөнөөс 1,543.6 сая төгрөгөөр,
- ✚ Импортын ЦЭХ-ний зардал: Ханги хилийн боомтоор импортоор худалдан авсан цахилгааны зардал 359.1 сая төгрөг, бусад үйл ажиллагааны зардал 30.0 сая төгрөг, нийт 389.1 сая төгрөгийн зардалтай, төлөвлөгөөнөөс 64.8 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн. (Хүснэгтээр)

“БЗӨБЦТС ТӨХК”-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



(сая төг-өөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүн	хувь
1. ХАЦЭХ-ний зардал	78,680.8	86,627.0	7,991.1	110.2%
2. Хангах, түгээх үйл ажиллагааны зардал	26,753.3	26,379.5	(373.7)	(1.40%)
3. Үйл ажиллагааны бус зардал	3,769.8	5,313.4	1,543.6	140.9%
4. Импортын ЦЭХ-ний зардал	324.3	389.1	64.8	120.0%
Нийт дүн	109,528.3	118,754.0	9,225.7	108.4%

Хангах, түгээх үйл ажиллагааны зардлын талаар:

Хангах, түгээх үйл ажиллагааны зардалд нийт **28** нэр төрлийн, **26,753.3** сая төгрөгийн зардал төлөвлөснөөс гүйцэтгэлээр **28** нэр төрлийн, нийт **26,379.5** сая төгрөгийн зардалтай, төлөвлөгөөнөөс **373.7** сая төгрөгөөр бууу **1.4** хувиар хэмнэсэн. (Хүснэгтээр)

/ мян. төгрөгөөр /

№	Зардлын төрөл	Мөрийн дугаар	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Тайлант оны		Өөрчлөлт	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өмнөх оноос	Төлөвлөгөөнөөс
1	Шатахууны зардал	1	245,706.8	326,042.9	345,743.3	100,036.4	19,700.4
2	Сэлбэг хэрэгсэл	2	169,696.2	122,650.9	150,905.0	(18,791.2)	28,254.2
3	Урсгал засвар	3	300,313.3	272,158.7	310,000.0	9,686.7	37,841.4
4	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	4	11,004,259.2	12,126,839.5	12,125,285.3	1,121,026.2	(1,554.1)
5	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	5	1,640,632.9	1,749,419.2	1,749,264.3	108,631.3	(154.9)
6	Ашиглалтын зардал-Цахилгаан	6	194,098.2	256,572.0	240,947.6	46,849.4	(15,624.4)
7	Ашиглалтын зардал-Дулаан	7	218,983.6	241,460.4	257,451.8	38,468.2	15,991.4
8	Ашиглалтын зардал-Ус	8	8,566.0	13,497.2	11,404.2	2,838.2	(2,092.9)
9	Албан томилолтын зардал	9	101,738.0	133,985.0	163,976.1	62,238.1	29,991.1
10	Конторын хангамжийн зардал	10	68,803.0	76,335.7	82,633.1	13,830.1	6,297.5
11	Харилцаа холбооны зардал	11	115,469.9	133,341.0	110,813.9	(4,656.0)	(22,527.1)
12	Хөдөлмөр хамгааллын зардал	12	253,562.5	355,192.8	358,031.2	104,468.7	2,838.4
13	Даатгалын зардал	13	21,286.0	18,172.9	19,510.0	(1,776.0)	1,337.1
14	Гүйцэтгэх удирдлагын зардал	14	352,434.3	215,576.5	231,244.5	(121,189.8)	15,668.0
15	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	15	97,927.2	101,126.9	102,800.0	4,872.8	1,673.1
16	Борлуулалт, маркетингийн зардал	16	55,926.7	41,018.3	40,486.8	(15,439.9)	(531.5)
17	Диспетчерийн зардал	17	738,856.5	759,146.2	759,146.2	20,289.7	(0.0)
18	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	18	64,800.0	76,800.0	76,800.0	12,000.0	-
19	Гадны үйлчилгээний хөлс	19	210,376.8	232,239.5	222,472.6	12,095.7	(9,766.9)
20	Түрээсийн зардал	20	24,002.7	28,600.1	28,450.1	4,447.4	(150.0)
21	Сургалтын зардал	21	87,885.5	61,220.0	62,570.7	(25,314.8)	1,350.7
22	Найдваргүй авлагын зардал	22	5,032.5				
23	Зар сурталчилгааны зардал	23	4,990.4	19,620.1	19,620.0	14,629.6	(0.0)
	Үйл ажиллагааны зардлын дүн	24	15,985,348.3	17,361,015.5	17,469,556.8	1,489,241.0	108,541.3
24	Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	25	7,533,591.6	7,865,786.7	7,658,269.2	124,677.6	(207,517.5)
	Элэгдлийн зардлын дүн	27	7,533,591.6	7,865,786.7	7,658,269.2	124,677.6	(207,517.5)
27	Үл хөдлөх хөрөнгийн татвар	28	69,292.5	70,710.6	70,837.9	1,545.4	127.3
28	АТӨЯХ-ийн албан татвар	29	4,516.3	4,909.2	4,373.0	(143.2)	(536.2)
29	Газрын төлбөр	30	3,974.6	4,379.2	4,588.0	613.4	208.8
30	Бусад татвар хураамж	31	28,107.2	37,372.6	20,083.2	(8,024.0)	(17,289.4)
31	Найваргүй авлагын зардал	32					
	Орлогын албан татвараас бусад татвар дүн	33	105,890.6	117,371.6	99,882.1	(6,008.5)	(17,489.5)
32	Хүүгийн зардал-Урт хугацаат зээл	34					
33	Ажиллагсдын нийгмийн зардал	35	1,230,629.4	1,409,100.6	1,151,824.2	(78,805.3)	(257,276.5)
	Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардал	36	1,230,629.4	1,409,100.6	1,151,824.2	(78,805.3)	(257,276.5)
	ТАРИФТ ЗАРДЛЫН НИЙТ ДҮН	37	24,855,459.9	26,753,274.4	26,379,532.3	1,524,072.3	(373,742.2)

Нийт **15** нэр төрлийн зардлыг төлөвлөгөөнөөс **535.0** сая төгрөгөөр хэмнэж, **13** нэр төрлийн зардал **161.3** сая төгрөгөөр хэтэрсэн байна. (Хүснэгтээр)



2022 оны зардлын хэтрэлт, хэмнэлт

/ мян. төгрөгөөр /

№	Зардлын төрөл	2022 он		Хэмнэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	12,126,839.5	12,125,285.3	(1,554.1)
2	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	1,749,419.2	1,749,264.3	(154.9)
3	Ашиглалтын зардал-Цахилгаан	256,572.0	240,947.6	(15,624.4)
4	Ашиглалтын зардал-Ус	13,497.2	11,404.2	(2,092.9)
5	Харилцаа холбооны зардал	133,341.0	110,813.9	(22,527.1)
6	Борлуулалт, маркетингийн зардал	41,018.3	40,486.8	(531.5)
7	Гадны үйлчилгээний хөлс	232,239.5	222,472.6	(9,766.9)
8	Түрээсийн зардал	28,600.1	28,450.1	(150.0)
9	Диспетчерийн зардал	759,146.2	759,146.2	(0.0)
10	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	76,800.0	76,800.0	-
11	Зар сурталчилгааны зардал	19,620.1	19,620.0	(0.0)
12	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	7,865,786.7	7,658,269.2	(207,517.5)
13	АТӨЯХ-ийн албан татвар	4,909.2	4,373.0	(536.2)
14	Бусад татвар хураамж	37,372.6	20,083.2	(17,289.4)
15	Ажиллагсдын нийгмийн зардал	1,409,100.6	1,151,824.2	(257,276.5)
ДҮН		24,754,262.0	24,219,240.6	(535,021.4)

№	Зардлын төрөл	2022 он		Хэтрэлт
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Шатахууны зардал	326,042.9	345,743.3	19,700.4
2	Сэлбэг хэрэгсэл	122,650.9	150,905.0	28,254.2
3	Урсгал засвар	272,158.7	310,000.0	37,841.4
4	Ашиглалтын зардал-Дулаан	241,460.4	257,451.8	15,991.4
5	Албан томилолтын зардал	133,985.0	163,976.1	29,991.1
6	Конторын хангамжийн зардал	76,335.7	82,633.1	6,297.5
7	Хөдөлмөр хамгааллын зардал	355,192.8	358,031.2	2,838.4
8	Даатгалын зардал	18,172.9	19,510.0	1,337.1
9	Гүйцэтгэх удирдлагын зардал	215,576.5	231,244.5	15,668.0
10	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	101,126.9	102,800.0	1,673.1
11	Сургалтын зардал	61,220.0	62,570.7	1,350.7
12	Үл хөдлөх хөрөнгийн татвар	70,710.6	70,837.9	127.3
13	Газрын төлбөр	4,379.2	4,588.0	208.8
ДҮН		1,999,012.4	2,160,291.7	161,279.3
НИЙТ ДҮН		26,753,274.4	26,379,532.3	(373,742.1)

Ажиллагсдын нийгмийн зардлын тайлан

/ мян. төг /

№	Зардлын нэр	Өнгөрсөн оны мөн үе	Тайлант үеийн			өөрчлөлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хүний тоо	өмнөх оны мөн үеэс	төлөв-нөөс
1	Шагнал, урамшуулал	146749.6	224230.0	51206.0	53	(95,543.6)	(173,024.0)
2	Тэтгэмж, буцалтгүй тусламж	86,157.7	76891.3	79033.0	68	(7,124.8)	2,141.7
3	Тэтгэвэрт гарч буй хүнд олгосон тэтгэмж	412,670.2	311834.9	267821.2	11	(144,849.0)	(44,013.7)
4	Сувиллын хөнгөлөлт	12,197.7	22700.0	3804.4	10	(8,393.3)	(18,895.7)
5	Хоолны хөнгөлөлт	521,870.4	536689.8	514740.0	550	(7,130.4)	(21,949.8)
6	Хоол, түлшний хөнгөлөлтийн НДШ	79,376.9	77820.0	79275.3	548	(101.6)	1,455.3
7	Түлшний хөнгөлөлт	36,540.0	37730.0	34720.0	496	(1,820.0)	(3,010.0)
8	Унааны хөнгөлөлт	4,609.8	5707.7	7915.7	98	3,305.9	2,208.0
9	Биеийн тамирын арга хэмжээ	2,447.0	115497.0	113308.7	158	110,861.7	(2,188.3)
10	Амралт, баяр ёслолын зардал	23,192.7	0.0	0.0	0	(23,192.7)	-
Нийт дүн		1,325,811.9	1,409,100.6	1,151,824.2		(173,987.7)	(257,276.4)

Үйл ажиллагааны бус зардалд нийт **3,769.8** сая төгрөгийн зардалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр **5,313.4** сая төгрөгийн зардалтай, төлөвлөгөөнөөс 1,543.6 сая төгрөгөөр хэтэрсэн. Үүнд:



- ✚ Гадаад валютын бодит бус ханшийн алдагдал: нийт **4,435.8** сая төгрөг, төлөвлөгөөнөөс 1,099.3 сая төгрөгөөр нэмэгдсэн. 2022 оны 3-р улирлын гүйцэтгэлээр ам. долларын ханш төлөвлөгөөнөөс 103.0 төг-өөр өссөнөөр 805.3 сая төг-ийн, 4-р улиралд 119.60 төгрөгөөр өссөнөөр 290.0 сая төг-ийн тус тус валютын бодит бус ханшийн алдагдал нэмэгдсэн.
- ✚ Хөрөнгө данснаас хассаны гарз: нийт **157.9** сая төгрөг, Засгийн газрын 2022 оны 5 сарын 11-ний өдрийн №190 "Орон сууц хувьчлах тухай" тогтоолоор Говьсүмбэр салбарын 9 ажилтны орон сууцыг хувьчилж, хөрөнгө данснаас хассан. (Хүснэгтээр)

Үйл ажиллагааны бус зардал

(мян. төг-өөр)

д/д	Үзүүлэлт	2022 он 4-р улирал		төлөв-нөөс
		Төлөв	Гүйцэт	
2. Бусад зарлага				
	Өндөр настантай холбоотой	73,499.5	59,273.5	(14,226.0)
	Өндөр настан ахмадуудад	29,180.5	30,714.5	1,534.0
1	ЭХТА-ны нэмэгдэл урамшуулал	16,702.5	14,989.0	(1,713.5)
	Тэтгэмж, буцалтгүй тусламж	13,591.5	10,920.0	(2,671.5)
	Түлээ нүүрс, сүвиллын хөнгөлөлт	14,025.0	2,650.0	(11,375.0)
	Баяр ёслолын арга хэмжээ	26,261.2	-	(26,261.2)
2	Бусад	3,889.2	-	(3,889.2)
	Хүүхдийн баярын а/х-ний зардал	22,372.1	-	(22,372.1)
	ТАА-н зардал	16,196.0	27,671.6	11,475.6
	Малчдын цалин шимтгэл	5,839.5	6,870.0	1,030.5
	Мал борлуулсан өртөг	1,485.4	2,098.0	612.6
3	Өвс, тэжээл, эм тарилга	2,171.8	4,612.6	2,440.9
	Шатахуун	5,540.3	11,503.0	5,962.7
	Малын хорогдол	1,159.1	2,588.0	1,428.9
4	Цайны газрын зардал	106,075.4	122,109.9	16,034.5
5	МШӨ-ний тэтгэмж	1,500.5	1,850.5	350.0
6	Гадаад валютын бодит бус ханшийн алдагдал	3,336,465.7	4,435,817.3	1,099,351.6
7	Тендерийн урилга зарын үнэ	-	9,204.0	9,204.0
8	Гүйлгээний шимтгэл	18,159.0	17,148.0	(1,011.0)
9	Хүүгийн зардал /богино хугацаат	-	270.3	270.3
10	Хохирлын төлбөр	-	11,390.8	11,390.8
11	Тэрбум мод хөтөлбөр	46,006.0	33,379.4	(12,626.6)
12	Бусад ББӨ	11,242.2	38,879.7	27,637.5
13	Барилга угсралт засвар үйлчил.	102,691.4	398,472.1	295,780.8
14	Хөрөнгө данснаас хассаны гарз	31,737.7	157,911.5	126,173.8
	Үйл ажиллагааны бус зардлын дүн	3,769,834.5	5,313,378.5	1,543,544.0

2.6. Зорилт:4-5 Татвар төлөхийн өмнөх, дараахь ашиг, алдагдал

Тайлант хугацаанд нийт **112,930.9** сая төгрөгийн орлоготой, **118,754.0** сая төгрөгийн зардалтай, татварын өмнөх **5,823.0** сая төгрөгийн, татварын дараахь **5,671.7** сая төгрөгийн тус тус алдагдалтай ажиллаж, төлөвлөгөөт алдагдлын дүн 1,208.6 сая төг-өөр нэмэгдсэн. Үүнд:

- ✚ үндсэн үйл ажиллагаанаас **1,746.1** сая төгрөгийн алдагдалтай, төлөвлөгөөт алдагдлыг 366.8 сая төг-өөр,
- ✚ үйл ажиллагааны бусаас **4,027.4** сая төгрөгийн алдагдалтай, төлөвлөгөөт алдагдлыг 924.4 сая төг-өөр тус тус нэмэгдүүлсэн.
- ✚ импортын ЦЭХ-нээс **49.5** сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан.

Төлөвлөгөөт алдагдлыг бууруулахад худалдан авсан ЦЭХ-ний хэрэглээний өсөлт, борлуулалтын дундаж үнийн өөрчлөлт, үйл ажиллагааны зардлын хэмнэлт, түгээлтийн



алдагдлын бууралтаас нийт **7,624.3** сая төгрөгийн **зэрэг нөлөөлөл**, төлөвлөгөөт алдагдлыг өсгөхөд худалдан авсан ЦЭХ-ний зардлын хэтрэлт, тарифын өөрчлөлт, үйл ажиллагааны бус орлого, зардлын болон импортын ЭХ-ний орлого, зардлын зөрүүгээс нийт **8,984.3** сая төгрөгийн **сөрөг нөлөөлөл** тус тус үзүүлсэн байна.

2.7. Зорилт:6 Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал

Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал 1.05 төг-ийн гүйцэтгэлтэй, борлуулалтын нэгжид ногдох зардал 0.01 төг-өөр хэтэрсэн.

2.8. Зорилт:7 Нийт авлага

Нийт авлага оны эхнээс **2,042.3** сая төгрөгөөр буурч, зорилтоос **1,072.9** сая төгрөгөөр нэмэгдэж, нийт **2,887.6** сая төгрөгийн үлдэгдэл авлагатай. Үүнд:

Үзүүлэлт	(сая төг-өөр)		
	Зорилт	Гүйцэтгэл	Зорилтоос
1. Хэрэглэгчээс авах авлага	1,425.0	2,681.1	1,256.1
2. Шөнийн тарифын авлага	352.9	89.0	(263.9)
3. Бусад авлага	36.8	117.5	80.7
Нийт дүн	1,814.7	2,887.6	1,072.9

Цэх-ний үлдэгдэл авлагын талаар:

ЦЭХ-ний авлага оны эхнээс 1,682.4 сая төг-өөр, зорилтоос 1,256.1 сая төг-өөр тус тус нэмэгдэж, нийт **2,681.1** сая төг -ийн авлагатай. ОУААГ-аас **897.1** сая төг-ийн, уул уурхайгаас **1,784.0** сая төг-ийн, шөнийн тарифын хөнгөлөлт **89.1** сая төг-ийн тус тус авлагатай.

ЦЭХ-ээр хангах гэрээний 6.6 заалтын дагуу дараа сарын 5-10-ны дотор төлбөр төлдөг дараахь томоохон хэрэглэгчид:

Үзүүлэлт	(сая төг-өөр)		
	Зорилт	Гүйцэтгэл	Зорилтоос
1. Монросцветмет ТӨҮГ	800.0	1,716.7	916.7
2. МАК цемент ХХК	300.0	511.7	211.7
3. Монцемент ХХК	175.0	-	(175.0)
4. СИ ӨҮ ЭЙ ЭЛ ХХК	100.0	-	(100.0)
5. БН Дулааны станц	50.0	382.3	332.3
6. Соёолон групп	-	22.3	22.3
7. Чулуут интернейшнл	-	10.0	10.0
8. Бусад ҮААГ	-	38.1	38.1
Нийт дүн	1,425.0	2,681.1	1,256.1



2.9. Зорилт:8 Нийт нийт өр төлбөр

Нийт **36,064.7** сая төгрөгийн өглөгтэй, үүнээс урт хугацаат өр төлбөр **35,031.6** сая төг-ийн, богино хугацаат өр төлбөр **1,033.1** сая төг-ийн тус тус өглөгтэй. Үүнд:

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөр оны эхнээс **20,174.5** сая төгрөгөөр, зорилтоос **1,765.1** сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, тайлант хугацааны эцэст **35,031.6** сая төгрөгийн өглөгтэй. (Хүснэгтээр)

(сая төг-өөр)			
Үзүүлэлт	Зорилт	Гүйцэтгэл	Зорилтоос
1. Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2” төслийн зээл	33,266.5	29,411.2	(3,855.3)
2. Хойшлогдсон татварын өр (санхүү, татварын элэгдлийн зөрүүгээс үүссэн)	-	5,611.9	5,611.9
3. Урт хугацаат өглөг	10.7	8,589.6	8,578.9
Нийт дүн	33,266.5	35,031.6	1,765.1

Богино хугацаат өр төлбөр

Богино хугацаат өр төлбөр оны эхнээс **697.4** сая төгрөгөөр нэмэгдэж, зорилтоос **1,225.1** сая төгрөгөөр буурч, тайлант хугацааны эцэст **1,033.1** сая төгрөгийн өглөгтэй. (Хүснэгтээр)

(сая төг-өөр)

№	Зардлын нэр	2022 он		
		Зорилт	Гүйцэтгэл	Зорилтоос
1	Нэг худалдан авагчид өглөг	1,920.6	-	(1,920.6)
2	ЦЭХ-ний урьдчилж төлсөн төлбөр	337.6	276.6	(61.0)
3	Дэлхийн банкны Эрчим хүч төслийн зээлийн хүүгийн өглөг	-	181.7	181.7
4	ААНОАТ-ын өглөг	-	344.9	344.9
5	НӨАТ-ын өглөг	-	112.8	112.8
6	Бэлтгэн нийлүүлэгчид өглөг	-	116.0	116.0
7	Урт хугацаат өр тайлант үеийн өглөг	-	1.1	1.1
	Дүн	2,258.2	1,033.1	(1,225.1)

✚ ЦЭХ-ний урьдчилж төлөгдсөн орлого:

- ✓ Компани -1.5 сая төгрөг,
- ✓ Багануур салбар -17.5 сая төгрөг,
- ✓ Дорноговь салбар - 33.5 сая төгрөг,
- ✓ Дундговь салбар - 50.0 сая төгрөг,
- ✓ Хэнтий салбар - 27.4 сая төгрөг,
- ✓ Говьсүмбэр салбар -146.8 сая төгрөг,

2.10. Зорилт: 9 Нийт ажиллагсдын тоо

Компани, 5 салбарын дүнгээр батлагдсан орон тоо **-555**, үүнээс Ханги хилийн боомтын шуурхай үйлчилгээ, засварын монтёрсн орон тоог импортын зардалд шилжүүлж тооцсоноор нийт **554** орон тоотой ажиллахаас гүйцэтгэлээр **548** орон тоотой, дунджаар 7 орон тоо дутуу ажилласан. Үүнд :



- ✚ Гүйцэтгэх удирдлага -2, (Эхний 4 сард 5 орон тоотой, 5-12 сард 1 орон тоотой ажиллаж, гүйцэтгэлийг дунджаар тооцсон)
- ✚ ИТА, албан хаагч -223
- ✚ Ажилчид -322,

2.11. Зорилт: 10 Нийт цалингийн сан

Нийт цалингийн сангийн зардалд **12,265.1** сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр **12,125.3** сая төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөгөөнөөс **139.8** сая төгрөгөөр хэмнэсэн.

2.12. Зорилт: 11 Нэг ажилтны дундаж цалин

Нэг ажилтны дундаж цалин ЖҮДНХ -тэй **1,870.0** мянган төгрөгийн, ЖҮДНХ-гүй **1,637.0** мянган төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй гарч, төлөвлөгөөнөөс **25.6** мянган төгрөгөөр, өнгөрсөн оны мөн үеэс **170.1** мянган төгрөгөөр тус тус илүү байна. Үүнд:

- ✚ Гүйцэтгэх удирдлага дундаж цалин -**5,825.1** мян.төг-ийн,
- ✚ ИТА, АХ дундаж цалин -**2,253.5** мян.төг-ийн,
- ✚ Ажилчид дундаж цалин -**1,574.6** мян.төг-ийн тус тус гүйцэтгэлтэй.

2.13. Зорилт: 12 Цахилгааны тасалдлын дундаж хугацаа (и-сайди)

Жилд нэг хэрэглэгчид ногдож буй тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа Исайди - 734.7 минут буюу өмнөх оны мөн үеэс 24.3 минутаар буурсан.

2.14. Зорилт: 13 Их засвар, тзбах, хөрөнгө оруулалт

Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр нийт 88 нэр төрлийн, 5,896.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэхээс нийт 83 нэр төрлийн, 4,742.3 сая төгрөгийн ажлыг 95.9 хувиар хийж гүйцэтгэсэн.




ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

3.1. Хүний нөөцийн удирдлага

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор тус компани нь нийт 558 орон тоотой ажиллахаар баталсныг Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 16 дугаар тогтоолоор нийт 555 орон тоотойгоор шинэчлэн баталсан.

Дээрх бүтцийн өөрчлөлтөөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу тус компанийн тэргүүн дэд захирал, дэд захирлуудын орон тоог хасан, ерөнхий инженер болон компанийн 8 хэлтэс, 5 албыг гүйцэтгэх захирал удирдлагаар ханган ажиллаж, Нэгдсэн сүлжээний дүрэм, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд техникийн үйл ажиллагаа явуулдаг алба хэлтсүүд болон харьяа салбарын техникийн болон шуурхай ажиллагааг техникийн дээд удирдлага буюу Ерөнхий инженер удирдан зохион байгуулж байна. Мөн батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан шаардлагатай орон тоо, албан тушаалуудыг дотоод нөөц бололцоондоо багтаан зохицуулж шилжүүлж ажилласан.



Компанийн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэн мөрдөхдөө Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж болон эрчим хүчний салбарын дүрэм, журам, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээ, Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилласан бөгөөд компанийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг тогтоосон дараах журмуудыг шинэчлэн боловсруулж, гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан. Үүнд:

1. Архивын ажлын журам (2022.02.11-ний өдрийн А/35 дугаар тушаал)
2. Хөдөлмөрийн дотоод журам (2022.04.19-ний өдрийн А/128 дугаар тушаал)
3. Мэдлэгийн шалгалт авах журам (2022.05.09-ний А/148 дугаар тушаал)
4. Албаны нууцыг хамгаалах журам (2022.05.27-ны өдрийн А/163 дугаар тушаал)
5. Шуурхай зөвлөгөөн зохион байгуулах журам (2022.06.17-ны өдрийн А/178 дугаар тушаал)



3.2. Хүний нөөцийн судалгаа

Компанийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар нийт 544 ажилтан ажиллаж байгаагаас эрэгтэй 317, эмэгтэй 227 ажилтан ажиллаж байгаа бөгөөд нийт ажилтнуудын 35% буюу дийлэнх хувийг 26-35 насныхан эзэлж байна.

Компанийн хэмжээнд 14 зөвлөх инженер, 26 мэргэшсэн инженер, 11 мэргэшсэн нягтлан бодогч ажиллаж байна.

Мэргэжлийн цол, зэрэг дэв	Төв компани	Хэнтий ЦТСС	Говьсүмбэр ЦТСС	Багануур ЦТСС	Дундговь ЦТСС	Дорноговь ЦТСС	Нийт
Магистр	5	0	4	5	1	1	16
Зөвлөх	8	1	1	2	2	0	14
Мэргэшсэн инженер	13	3	2	2	1	5	26
Мэргэшсэн нягтлан бодогч, төсөвчин	4	2	1	0	2	2	11

Компанийн боловсон хүчний мэргэжил боловсролыг дээшлүүлж, хүний нөөцийг бүрдүүлж ажилласан байдлыг судалж үзэхэд дээд боловсролтой 294, тусгай дунд 103, бүрэн дунд 137, бүрэн бус дунд 10 ажилтан байгаа ба үүнээс цахилгааны инженер 148, бусад инженер 25, санхүүгийн мэргэжилтэй нягтлан бодогч, эдийн засагч, банк санхүү, бизнесийн удирдлага 28, хуульч 1 цахилгаан техникч 28 байна.

Д/д	Боловсрол	Компани	Багануур	Дундговь	Дорноговь	Хэнтий	Говьсүмбэр	Нийт
1	Дээд	74	49	34	50	55	32	294
2	Тусгай дунд	12	4	24	8	16	39	103
3	Бүрэн дунд	7	24	16	34	43	13	137
4	Бүрэн бус дунд	1	1	3	2	2	1	10
	Нийт	97	78	76	96	114	92	544

Компанийн ажилтнуудын 58% нь эрэгтэй, 42% нь эмэгтэй, 0-15 жил ажиллаж байгаа 20-49 насны бага тушаалын ажилтан 50-55%, 25% ИТА нар эзэлж байна.


Д/д	Үзүүлэлт	Төв компани	Хэнтий ЦТСС	Говьсүмбэр ЦТСС	Багануур ЦТСС	Дундговь ЦТСС	Дорноговь ЦТСС	БЗӨБЦТС ТӨХК
1	18-25 нас	5	11	7	9	12	16	60
2	26-35 нас	36	40	20	21	37	36	190
3	36-45 нас	34	37	20	26	14	25	156
4	46-55 нас	14	24	29	16	13	16	112
5	56-65 нас	5	4	5	6	1	1	22




Ажилтнуудын боловсрол



Ажилтнуудын хүйсийн харьцаа



Ажилтнуудын мэргэжлийн ангилал (хувиар)



“БЗӨБЦТС ТӨХК”-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын тоон судалгаа (2022 оны жилийн эцсийн байдлаар)

Салбар	Нийт орон тоо	Ажлаас чөлөөлөгдсөн нийт ажилтны тоо	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын тухайн компанид ажилласан жил								Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудын боловсролын түвшин						Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтны тоо	
			0-5 жил		5-10 жил		10-15 жил		15-с дээш жил		Дээд		Тусгай дунд		Бүрэн дунд			
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
"БЗӨБЦТС ТӨХК"	555	149	97	65.1	24	16.1	8	5.4	11	9.5	88	59.1	24	16.1	37	24.8	112	75.2
Компанийн хэсэг	94	26	17	65.4	4	15.4	2	7.7	3	2.6	16	61.5	6	23.1	4	15.4	19	73.1
Багануур ЦТСС	78	32	24	75.0	3	9.4	2	6.3	3	2.6	26	81.3			6	18.8	23	71.9
Говьсүмбэр ЦТСС	93	26	19	73.1	7	26.9					14	53.8	5	19.2	7	26.9	21	80.8
Дорноговь ЦТСС	97	24	15	62.5	2	8.3			1	0.9	12	50.0	2	8.3	10	41.7	19	79.2
Дундговь ЦТСС	77	10	4	40.0	3	30.0					5	50.0	3	30.0	2	20.0	1	10.0
Хэнтий ЦТСС	116	31	18	58.1	5	16.1	4	12.9	4	3.4	15	48.4	8	25.8	8	25.8	29	93.5

Ажилд томилогдсон ажилтнуудын тоон судалгаа (2022 оны жилийн эцсийн байдлаар)

Салбар	Нийт ажилтан	Шинээр томилогдсон ажилтны тоо	Шинээр томилогдсон ажилтны албан тушаал							
			УАТ		АХ		ИТА		БТА	
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
"БЗӨБЦТС ТӨХК"	555	141	7	21.739	20	81.901	46	199.3	68	275.22
Компанийн хэсэг	94	23	3	13.0	6	26.1	6	26.1	8	34.8
Багануур ЦТСС	78	32	1		4	12.5	11	34.4	16	50.0
Говьсүмбэр ЦТСС	93	23	2	8.7	2		8	34.8	11	47.8
Дорноговь ЦТСС	97	22			3	13.6	7	31.8	12	54.5
Дундговь ЦТСС	77	10	1		2	20.0	4	40.0	3	30.0
Хэнтий ЦТСС	116	31			3	9.7	10	32.3	18	58.1



3.3. Шүүхийн маргаан, хөдөлмөрийн харилцаа

Говьшоо ХХК-иас нэхэмжилсэн ЦЭХ-ний төлбөр 174.2 сая төгрөгийг гаргуулах нэхэмжлэлийг Баянгол дүүргийг иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргаж шүүх хуралд хариуцагч эвлэрлийн гэрээ байгуулах, өр авлага хэсэгчлэн барагдуулах хүсэлтийн дагуу шүүгчийн захирамж гаргуулж ажилласан ба төлбөрийг бүрэн төлж барагдуулаагүй тул Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлт гаргуулан төлбөрийг бүрэн барагдуулсан.

Соёолон групп ХХК-иас цахилгаан эрчим хүчний хуримтлагдсан төлбөр- 155.1 сая төгрөг гаргуулах нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх хугацаанд талууд эвлэрлийн гэрээ байгуулж өр авлага хэсэгчлэн барагдуулах гэрээний дагуу төлбөрийг төлж барагдуулсан.

Багануур дүүргийн 1-р хороо 78-р байрны 2 айлын цахилгаан хэрэгсэл шатаж хохирол учруулсан иргэний хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж нэг айлын төлбөрийг хэрэгсэхгүй болгож, нөгөө айлын төлбөрөөс хасуулж шийдвэрлэсэн ба давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн дагуу төлбөрийг компаниас төлж барагдуулснаар уг хэрэг хаагдсан.

Багануур дүүргийн 3-р хорооны иргэн 50-44 тоотын оршин суугч Д.Базаргүрийн нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж, зохих шүүхийн шийдвэрийг гаргуулсан.

Багануур ус ААҮТГ-ын хохирол нэхэмжилсэн улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралд зохих шүүхийн шийдвэрийг гаргуулсан.

2022 онд Говьсүмбэр ЦТСС-ын Бор-Өндөр хэсэгт болсон осолтой холбоотой эрүүгийн хэрэг болон Бигом Чойртой холбоотой иргэний хэрэгт итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон эрх бүхий байгууллагад хүргүүлсэн.

2022 онд Гүйцэтгэх захирлын Б тушаал буюу хүний нөөцтэй холбоотой 381 тушаал гарснаас 303 (79,5 хувь) тушаалыг хянаж баталгаажуулсан, А тушаал буюу үйл ажиллагаатай холбоотой 363 тушаал гарснаас 168 (46,2 хувь) тушаалыг хянаж баталгаажуулсан байна. Мөн гүйцэтгэх захирлын А тушаалын биелэлтийг нэгтгэж гаргасан.

ХАСУМ 25 хүнээс, ХАСХОМ 43 албан тушаалтнаас, 136 мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан.

Харьяа салбарт хууль зүйн зөвлөгөө зөвлөмжийг утас, дотоод сүлжээгээр 158 удаа, Нийт компанийн хэсгийн ажилтнуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу хуулийн зөвлөгөөг 211 удаа ажилтнуудад өгч ажилласан.

Шинэчлэн боловсруулсан 20 журам, дүрмийн төсөлд санал өгч, хяналт хийсэн.

Хөдөлмөрийн гэрээг 127 ажилтантай Сэлгэн ажиллуулах гэрээг 3 ажилтантай Хөлсөөр ажиллуулах гэрээг 11 хүнтэй байгуулсан. ХАА-ны 92 болон бусад нийт 104 гэрээг хянасан. Салбарын дарга нартай 2023 онд байгуулах онцгой нөхцөл бүхий гэрээний төслийг боловсруулсан.

МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР

Нийт 163 удаагийн хувийн ашиг сонирхлын мэдэгдэл, тайлбарыг гаргуулан авч, meduuleg.iaac.mn системд бүртгэж оруулсан.

3.4. Албан хэрэг хөтлөлт, архив бичиг хэргийн ажилд хийсэн хяналт шалгалт, тооллогын ажлын үр дүн, бүртгэл, хөтлөлтийн талаар хийсэн ажил:

Архивын сан хөмрөгийн тоо баримт



Компанийн албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн баримт материалыг зохион байгуулалтын нэгж, ажилтнаас байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, байгууллагын архивын тухай журамд заасны дагуу бүрдүүлж, архивын баримт нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтад заасан хугацаагаар хадгалан ажилласан.


Д/д	Бүртгэлийн жагсаалт	Харьяа нэгж	2020 он	2021 он	2022 он
1	Байнга хадгалах хадгаламжийн нэгж	Компани	739	752	770
		БЦТСС	44	47	49
2	Түр хадгалах хадгаламжийн нэгж	Компани	2062	2107	2173
		БЦТСС	974	1016	1065
3	70 жил хадгалах хадгаламжийн нэгж	Компани	154	168	182
		БЦТСС	78	91	104
Нийт	Техникийн баримт бичгийн хадгалах хадгаламжийн нэгж	Компани	535	552	567
			4586	4733	4910



Хадгаламжийн данс бүртгэл хөтлөлт

Компанийн салбар хэлтэс алба, нэгжийн ажилтнуудаас Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам, стандартын дагуу баримтыг архивд хүлээн авч хадгалах хадгаламжийн нэгжээр ангилан ажилласан.

Д/д	Бүртгэлийн жагсаалт	Харьяа нэгж	2020 он	2021 он	2022 он
1	Байнга хадгалах хадгаламжийн нэгж	Компани	13	18	21
		БЦТСС	3	2	2
2	Түр хадгалах хадгаламжийн нэгж	Компани	45	66	78
		БЦТСС	42	49	59
3	70 жил хадгалах хадгаламжийн нэгж	Компани	14	14	-
		БЦТСС	13	13	-
4	Техникийн баримт бичгийн хадгалах хадгаламжийн нэгж	Компани	17	15	19
Нийт			147	177	179



Албан бичгийн эргэлтийн мэдээ:

Д/д	Баримт бичгийн нэр	2020 он	2021 он	2022 он
1	Явсан бичиг	1182	1154	1318
2	Ирсэн бичиг	1187	1299	1816
3	Гүйцэтгэх захирлын тушаал	494	594	746
4	Өргөдөл гомдол	163	200	389
5	Шуудан болон ажилтнуудад өгч явуулсан бичиг	524	521	701
6	Компанийн ажилтнуудад өгсөн тушаал, албан бичиг	1114	1076	1435
7	Архиваас түр олгосон баримт	344	214	89
8	Архиваас олгосон баримт	64	150	256
9	Ажилтнуудад өгсөн албан томилолт	390	355	393

Компани болон харьяа салбаруудын архив, бичиг хэргийн ажилтнуудыг MNS 5140-1 : 2021 - Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт, MNS 5140-2 : 2021-Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага, MNS 5140-3 : 2021 - Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавих шаардлага стандартаар хангасан.

Стандартын дагуу бичиг хэргийн ажилтнуудаас мэдлэгийн шалгалтыг цахимаар зохион байгуулж, баримт бичгийн стандартыг мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллаж байна.

3.5. Сургалтын чиглэлээр

Компанийн 2021 оны сургалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, нийт ажилтнуудаас авсан санал хүсэлт, судалгаа, эрчим хүчний салбарын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын сургалтын төлөвлөгөө, шаардлагад тулгуурлан 2022 оны сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулан гүйцэтгэх захирлаар батлуулж, төлөвлөгөөний дагуу биелэлтийг хангаж ажилласан.

Нийт 1521 цагийн сургалтыг гаднын ААН байгууллага, иргэн, хувь хүмүүсээс авахаас гадна компанийн дотоод нөөц бололцоог ашиглан нийт зөвлөх, мэргэшсэн болон магистр, бакалаврын зэрэгтэй 84 инженер техникийн ажилтан, албан хаагчид зааж, давхардсан тоогоор 5314 ажилтанд ээлжит сургалтыг зохион байгуулсан.



Дээрх графикаас 2021 онд дэлхий дахинд тархсан корона вируст цар тахлаас шалтгаалан тасалдаад байсан сургалтын үйл ажиллагаа 2022 оноос хэвийн горимд шилжиж байгаа нь харагдаж байна.

Компанийн хэсгийн ажилчдын ээлжит сургалтын ирцийг ерөнхийд нь графикаар харвал:



Графикаас харахад дунджаар ажилчдын 72,5% нь ээлжит сургалтад хамрагдсан байна.

Сургалтад хамрагдаагүй шалтгаануудаас дурдвал:


- 2022 оны худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт боловсруулах;
- 2021 оны санхүүгийн тайлан баланс гаргах;
- 2022 онд ДҮТ ТӨХХК-иас ирэх шалгалтад удирдамжийн дагуу бичиг баримт цэгцлэх, бэлтгэх;
- Дээд байгууллагаас ирсэн яаралтай албан бичигт хариу хүргүүлэх гэх мэт.



Ээлжит шалгалт

“Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм”-ийн дагуу 2022 оны ээлжит мэдлэгийн шалгалтыг компанийн 53, салбарын 157 ажилтнаас авсаас 156 ажилтан тэнцэж, мэдлэгийн түвшин тогтоох, аюулгүй ажиллагааны эрхийн үнэмлэхийн сунгалт хийж, цахилгаан байгууламжид ажиллах эрх олгосон. Шалгалтад хангалтгүй дүгнэгдсэн Багануур салбарын 35/6кВ Цэнхэрмандал д/ст-ын ШҮЗТ Э.Тамжидын хөдөлмөрийн гэрээг “Эрчим хүчний ажилтны дунд зохиох үндсэн дүрэм”-ийн 15.25 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.2 дахь заалтыг үндэслэн цуцалсан.

Ээлжит шалгалтыг бичгээр авдаг байсан бол 2022 оны ээлжит шалгалтыг компьютер ашиглан цахимаар болон ур чадварын шалгалт авсан нь өмнөх онуудаас онцлог болсон.



Компанийн мэргэжлийн шалгалтын комиссыг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/25 тоот тушаалаар шинэчлэн баталж, Компанийн ажилтнуудаас мэдлэгийн шалгалт авах журмыг 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/148 тоот тушаалаар шинэчилж батлан, мөрдөж байна.

Сургалтын гэрээ

Компанийн зардлаар сургалтад хамрагдаж байгаа иргэн, ажилтантай болон төлбөртэй сургалтын үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, ААНБ-тай сургалтын гэрээг тогтмол байгуулан сургалтыг гэрээнд заасны дагуу авч дуусмагц гэрээг дүгнэн ажилласан.

2022 онд нийт сургалтын 28 гэрээ байгуулсан байна. Үүнд:




Сургалтын зардал:


2022 оны сургалтын зардлыг 69,53 сая төгрөгөөр төсөвлөсөн. Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 62,57 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж 1,3 сая төгрөгийн хэтрэлттэй барьж ажилласан.



Сургалтын зардлыг өмнөх онтой харьцуулсан график (сая.төг)



Сургалтын зардлыг сургалтын төрлөөр ангилж үзвэл:



Сургалтын төрлийг өмнөх онтой харьцуулан хүснэгтээр үзүүлбэл:

Д/Д	СУРГАЛТЫН ТӨРӨЛ	2021 ОН	2022 ОН
1	2	3	4
1	Магистр, бакалавр	24.04 сая.төг	0 √
2	ИТА нарын мэргэжил дээшлүүлэх сургалт	13.72 сая.төг	17.29 сая.төг ↗
3	Бусад ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх сургалт	1.38 сая.төг	1.69 сая.төг ↗
4	Ажлын байрны ээлжит, ээлжит бус сургалт	4.75 сая.төг	14.294 сая.төг ↗
5	ХАБЭА-н сургалт	2.25 сая.төг	6.75 сая.төг ↗
6	Ажилтныг мэргэшүүлэх сургалт	24 сая.төг	7.68 сая.төг √
7	Бусад ажилтнуудын мэргэшүүлэх сургалт	6.59 сая.төг	0 √
8	А3 эрх олгох, сунгах сургалт	2.37 сая.төг	2.13 сая.төг √
9	Ажлын байрны дасгал сургалт	7.08 сая.төг	1.13 сая.төг √
10	Бусад сургалт семинар зөвлөгөөн	4.34 сая.төг	0 √
11	Ном сэтгүүл	0	10.7 сая.төг ↗
	НИЙТ	87.9 сая.төг	62.57 сая.төг



ДӨРӨВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

4.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөө, гүйцэтгэл


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах 4 чиглэлээр **25** ажил төлөвлөснөөс **24** ажил буюу **96%**-г бүрэн хийж гүйцэтгэсэн.



Д/д	2020 он		2021 он	
	Төлөвлөгөө (сая.төг)	Гүйцэтгэл (сая.төг)	Төлөвлөгөө (сая.төг)	Гүйцэтгэл (сая.төг)
Дүн	305,8	274,2	314,6	255,4

4.2. Осол зөрчлийн судалгаа, урьдчилан сэргийлэхээр хийсэн ажил

ДАСГАЛ ЗААВАРЧИЛГАА (3 ЖИЛЭЭР)

Д/д	Дасгал, зааварчилгааны төрөл			2020 он	2021 он	2022 он	
1	Зааварчилгаа авсан хүний тоо	Урьдчилсан		160	124	218	
2		Анхан шатны		147	97	212	
3		Давтан	Ээлжит	Өдөр тутмын	51945	49175	84229
4				Сарын давтан	2775	4435	4332
5			Ээлжит бус		5900	6136	7374
6		Тухайлсан		11357	10853	12046	
7	Дасгал	АЭД	Дасгалын тоо	191	159	178	
8			Хамрагдсан хүний тоо	2680	2607	2883	
9		ГЭД	Дасгалын тоо	135	69	88	
10			Хамрагдсан хүний тоо	2171	2423	2617	





ХАБЭА-н III шатны үзлэг шалгалт хийхдээ дасгал, зааварчилгаа чанартай явагдаж байгаад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 101 дүгээр тушаалаар батлагдсан “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн 3 дугаар заалтыг үндэслэн “Наряд болон шийдвэрээр гүйцэтгэх ажлыг зохион байгуулах журам”-ыг шинэчлэн гаргаж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласнаар компанийн хэмжээнд аваар осолгүй ажилласан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, Дэд бүтцийн сайдын 2003 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 125 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм”ийн 1 дүгээр зүйлийн 1.5.1, 1.5.4, 1.6.1 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 102 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм”ийн 1 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, 16 зүйлийн 16.1, 16.2, 16.3 дахь заалтуудыг үндэслэн компанийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмын ашиглалтын түвшин тогтоох, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг, шалгалтыг зохион байгуулах “Үзлэг шалгалт хийх журам”-ыг шинэчлэн батлуулж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж байна.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.6 дахь заалтуудыг үндэслэн ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах арилгах зорилгоор компанийн хэмжээнд мөрдөгдөх “Аюулыг мэдээлэх хуудас ашиглах журам”-ыг шинэчлэн гаргаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

4.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ээлжит үзлэг, шалгалт

Компанийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмын ашиглалтын түвшин тогтоох, ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг, шалгалтыг зохион байгуулах “ Үзлэг шалгалт хийх журам”-ын хэрэгжилтийг ханган үзлэг шалгалт хийсэн ажлын дүн:

2022 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ХАБЭА-Н 3 ШАТ БОЛОН АТТ ҮЗЛЭГИЙН ДҮН							
2022 оны 06 дугаар сарын 23				Багануур дүүрэг			
Д/д	Салбар	ХБ	Нийт зөрчил	АТТ %	Гэмтэл	Зөрчил	Бичиг баримтын зөрчил
1	2	3	4	5	6	7	8
1	Говьсүмбэр	54	325	84%	24	180	121
2	Дорноговь	51	431	79%	15	235	181
3	Дундговь	58	405	78%	22	302	81
4	Багануур	58	474	75%	22	323	129
5	Хэнтий	70	575	73%	43	399	133
Нийт		291	2210	78%	126	1439	645

2022 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХАБЭА-Н 3 ШАТ БОЛОН АТТ ҮЗЛЭГИЙН ДҮН							
2022 оны 12 дугаар сарын 30				Багануур дүүрэг			
Д/д	Салбар	ХБ	Нийт зөрчил	АТТ %	Гэмтэл	Зөрчил	Бичиг баримтын зөрчил
1	2	3	4	5	6	7	8
1	Говьсүмбэр	42	135	88%	14	97	24
2	Дорноговь	29	123	88%	3	74	46
3	Дундговь	28	146	80%	15	116	15
4	Багануур	32	219	80%	11	144	64
5	Хэнтий	40	235	79%	11	188	36
Нийт		171	858	83%	54	619	185



2022 ОНЫ ХАБЭА-Н 3 ШАТ БОЛОН АТТ ҮЗЛЭГИЙН НЭГДСЭН ДҮН							
2022 оны 12 дугаар сарын 30				Багануур дүүрэг			
Д/д	Салбар	ХБ	Нийт зөрчил	АТТ %	Гэмтэл	Зөрчил	Бичиг баримтын зөрчил
1	2	3	4	5	6	7	8
1	Говьсүмбэр	96	460	86%	38	277	145
2	Дорноговь	80	554	84%	18	309	227
3	Дундговь	86	551	78%	37	418	96
4	Багануур	90	693	78%	33	467	193
5	Хэнтий	110	810	76%	54	587	169
Нийт		462	3068	80%	180	2058	830

ГҮЙЦЭТГЭЛ:

2022 ОНЫ ХАБЭА-Н 3 ШАТ БОЛОН АТТ ҮЗЛЭГИЙН ГҮЙЦЭТГЭЛ										
2023 оны 02 дугаар сарын 28							Багануур дүүрэг			
Д/д	Салбар	ХБ	Нийт зөрчил	Гэмтэл	Устаагүй	Зөрчил	Устаагүй	Бичиг баримтын зөрчил	Устаагүй	Гүйцэтгэл
1	2	3	4	6	7	8	9	10	11	12
1	Говьсүмбэр	96	460	38	1	277	3	145	0	98%
2	Дорноговь	80	554	18	1	309	19	227	0	96%
3	Дундговь	86	551	37	0	418	10	96	0	98%
4	Багануур	90	693	33	0	467	26	193	0	96%
5	Хэнтий	110	810	54	3	587	36	169	0	95%
Нийт		462	3068	180	5	2058	94	830	0	97%

Компанийн хэмжээнд тоног төхөөрөмжийн ашиглалтын түвшнийг тогтоох ээлжит үзлэгийг 2022 оны 2, 4 дүгээр улиралд Дундговь, Хэнтий, Багануур, Говьсүмбэр, Дорноговь салбарын эзэмшлийн дэд станц, шугам тоноглолд 2 удаа зохион байгуулж, илэрсэн гэмтэл зөрчлийг устгах хугацаатай үүрэг даалгавар өгч, салбаруудын хийсэн ажлын гүйцэтгэлийг зургаар баталгаажуулан авч ажилласан.



ТАВ. ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН АЖЛУУД

5.1. Техникийн нөхцөл олголтын талаар:

Техникийн нөхцөл олгоход юуны өмнө хэрэглэгчдийн хэрэглээний шинж чанар, ачааллын хэмжээ, хүчин чадлыг судалж, түгээх сүлжээний хүчин чадал, техникийн боломжийг харгалзан үзээд орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хэрэглэгчийн шугам сүлжээ, дэд станцуудыг угсруулах, модон тулгууруудыг төмөр бетон тулгуураар солих, 0,4 кВ-ын сүлжээний алдагдал бууруулах зорилгоор АС маркийн утсыг бүрээстэй дамжуулагч /СИП/ утсаар солих, ачаалалд нь тохирсон гүйдлийн трансформатор, тоолуур зэрэг тооцооны хэрэгслийг дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-ын шаардлагад нийцэхээр, мөн тосон таслууруудыг вакуум болон элегаз, реклоузер таслуураар солиулж микропроцессорын хамгаалалттай болгох, найдвартай ажиллагааг хангах, түгээх сүлжээний алдагдлыг бууруулах зорилгоор хүчний трансформаторуудыг хамгийн ашигтай горимоор ажиллаж байхаар, алдагдал багатай хүчний трансформатор тавих, аюулгүй ажиллагааны үүднээс хот, төв суурин газруудад КТПН, хаалттай хуваарилах байгууламж барих зэрэг шаардлагуудыг техникийн нөхцөл олгоход хэрэгжүүлж ажиллалаа.

Компанийн эзэмшлийн 6-35 кВ-ын хүчдэлийн түвшинд цахилгаан эрчим хүчинд холбуулахаар 185 хэрэглэгч техникийн нөхцөл хүссэн албан хүсэлт ирүүлснээс **168** хэрэглэгч буюу шинээр **53.5** мВА суурилагдсан хүчин чадал бүхий техникийн нөхцөл олгосон байна.

2022 оны байдлаар 6-35 кВ-ын нийт олгогдсон техникийн нөхцөлийн 46 хэрэглэгчийн 14.8 мВА суурилагдсан чадалтай хэрэглээ эрчим хүчний системд холбогдоод байна. Олгогдоогүй үлдсэн бусад хэрэглэгчдийн хувьд горимын тооцоогоор түгээх сүлжээнд холбох боломжгүй гарсан байна. Горимын тооцоогоор түгээх сүлжээнд холбох боломжгүй гарсан хэрэглэгчдэд тухай бүрд нь албан бичгээр хариу хүргүүлсэн.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тухайн улирлын
Техникийн нөхцөл хүсч өргөдөл гаргасан иргэд, ААНБ	тоо	185
Цахилгаан чадал	МВА	58.8
Техникийн нөхцөл олгосон иргэд, ААНБ	тоо	168
Цахилгаан чадал	МВА	53.5
Цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон иргэд, ААНБ	тоо	46
Цахилгаан чадал	МВА	14.8
Техникийн нөхцөл олгоогүй өргөдлийн тоо	Тоо	17
Цахилгаан чадал	МВА	5.3

Техникийн нөхцөлийг олгохдоо тухайн албан байгууллага, хувь хүний хүсэлт гаргасан өргөдлийн дагуу тухайн салбарын ТҮАХМ,ЕИ газар дээр нь очиж үзэн холболтын цэгийг шийдвэрлэж байна.

Хэрэглэгчид хэрэглээ буюу чадлыг буруу тооцсоны үүднээс дэд станцуудын чадал өндөр тавигдаж, анх захиалсан эрчим хүчээ авахгүй байдал бий болж байна. Иймээс хэрэглэгчид тохирсон хүчин чадлыг сонгох бусад заавар зөвлөмжүүдийг өгч ажиллалаа.

Техникийн нөхцөлийн дийлэнх буюу 609 хэрэглэгч буюу 78 хувийг 0.4 кВ-ын техникийн нөхцөл олголт эзэлж байна.

Хэрэглэгчдийг тасралтгүй найдвартай цахилгаан эрчим хүчээр хангах, тасралт сааталгүй, алдагдлыг бууруулж, шинэ техник, технологи нэвтрүүлэх, түгээх сүлжээнд холбогдож байгаа хэрэглэгчдийг орчин үеийн дэвшилтэт, байгаль экологид сөрөг нөлөөгүй тоног төхөөрөмж хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.




2022 онд олгосон техникийн нөхцөл (график)



Хүснэгт 3. Техникийн нөхцөл олголтын тоо, чадлын хэмжээ

Д/д	Салбарын нэр	Техникийн нөхцөлийн хүсэлт	Олгосон		Олгоогүй
			тоо	чадал МВА	
2020 он					
1	Багануур	35	34	11.6	1
2	Говьсүмбэр	38	36	11.3	2
3	Дорноговь	40	33	11	7
4	Дундговь	14	14	4.2	0
5	Хэнтий	58	51	15.2	7
Нийт		185	185	53.5	17

Зураг 3. 2022 онд олгосон техникийн нөхцөл, түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн судалгаа (график)



Цахилгаан эрчим хүчний хэрэглээ жил бүр тогтвортой өсөн нэмэгдэж байна. Одоогийн схем, ЦДАШ, дэд станц, тоноглолын хүчин чадал болон горимоор Хэнтий аймгийн төв, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Батширээт, Биндэр, Норовлин, Галшар, Төв аймгийн Мөнгөнморьт, Дорноговь аймгийн Иххэт сумдад өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, техникийн нөхцөл олгоход хүндрэлтэй байна. Цаашид өсөн нэмэгдэж байгаа



хэрэглээг хангахын тулд горим тооцооллын дагуу хүчдэлийн түвшин, хүчин чадал нэмэгдүүлэх техник зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай байна.

5.2. Төсөв, судалгаа, төлөвлөлтийн ажлын талаар:

Компанийн тайлант жилийн хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний сонгогдсон ажлуудын техник эдийн засгийн үр ашиг, өгөөжийг дээшлүүлэх, засварын ажлын эзлэхүүн, өртгийг оновчтой зөв, судалгааг үндэслэлтэй тодорхойлон тооцож, төлөвлөлтийг хийх мөн засварын ажлын явцын гүйцэтгэлд мониторинг хийх, техникийн дотоод хяналт хийж ажлыг хүлээн авах, холбогдох баримт, акт, протоколуудыг бүрэн үйлдэж байх зорилгоор төлөвлөгдсөн ажил нэг бүр дээр төсвийн тооцооллыг хийн ажиллаж байна.

- Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын цахилгаан хангамжийн ажлын хүрээнд 35/6/15 кВ Зүүнбаян дэд станцын өргөтгөл 35 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийн төсвийг хийж гүйцэтгэсэн ба 2022 онд тус 35 кВ-ын ХХБ-аас тэжээгдэх 35 кВ-ын ЦДАШ-ын гаргалгааны хос 35 кВ-ын кабель шугамын төсвийг хянаж гүйцэтгэсэн болно. Шинэчилсэн төсвийн дагуу дээрх ажлыг манай компани хийж гүйцэтгэсэнээр 22,000,000.00 төгрөгийн ашигтай ажилласан.

- Тус компанийн үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт 2022-2023 онд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэх доорх Эрчим хүчний барилга угсралтын ажлуудын төсвийг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Багануур дүүргийн 3 дугаар хороонд байрлах 6 кВ-ын РП-2 ХХБ-ын 6 кВ-ын ячейк №7, Задгай-1-ын 6 кВ-ын ЦДКШ-ын угсралтын ажлын төсөв (Төсөвт өртөг- 102,584,218.0 төгрөг)
- Хэнтий аймаг, Өмнөдэлгэр сумын 20 ортой эмнэлгийн цахилгаан хангамжийн угсралтын ажлын төсөв (Төсөвт өртөг-121,005,551.0 төгрөг)
- Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Лүн хорооллын цахилгаан дамжуулах агаарын шугам, цахилгаан хангамжийн ажлын төсөв (Төсөвт өртөг-112,359,373.0 төгрөг)
- Хэнтий аймгийн Биндэр, Норовлин, Батширээт сумын 15 кВ цахилгаан дамжуулах агаарын шугамын хийц өөрчлөх ажлын төсөв (Төсөвт өртөг- 3,696,279,171.86 төгрөг)
- Ханги 35 кВ-ын ЦДАШ-ын төсөв (урьдчилсан байдлаар)
- Хэнтий аймгийн Дадал сумын нутаг дэвсгэрт баригдах “Чингис хаан аялал жуулчлалын цогцолбор”-ын цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлын төсөв-багц 4 (Төсөвт өртөг- 1,606,580,936 төгрөг)

5.3. Их засвар, ТЗБАХ-ний болон хөрөнгө оруулалтын ажлын чиглэлээр

Засварын ажлуудыг гүйцэтгэхдээ компанийн нэг маягийн ажлын зургаар, зайлшгүй шаардлагатай ажлууд дээр тусгайлан эрх бүхий байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн ажлын зураг гаргуулан ажилласан.

Зураг, төсвийн дагуу засварын ажлыг хийж гүйцэтгэсэнээр хийгдэх болон хүлээн авах ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлд тавигдах техникийн хяналт зэргүүд нь тодорхой болохоос гадна засварын ажлын материал сэлбэгийн төрөл, тип, марк, зориулалт, онцлог шаардлагууд, тоо хэмжээ гэх мэт техникийн шаардлага, тодорхойлолтууд нь тодорхой болж байна. Энэ нь материал, сэлбэгийн худалдан авах үйл ажиллагаанд эергээр нөлөөлж байгаа болно.

Компанийн жил бүрийн их болон урсгал засварын ажлуудын эзлэхүүнийг харьяа салбарын инженерүүд, засварын инженерүүдийн хамт оновчтой зөв тодорхойлж, сонгож



авах мөн түүнчлэн Хөрөнгө оруулалт болон ТЗБАХ-ний ажлын хүрээнд схем, горимын оновчтой шийдэл, техник, технологийн шинэчлэлт, шинэчилсэн бүтээн байгуулалт, шинэ техник, дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр:

- Тоноглолын ашиглалтын түвшнийг дээшлүүлэх
- Засварын зардлыг бууруулах
- Үр ашигтай горимоор ажиллуулах
- Техник болон аюулгүй ажиллагааг хангах
- Тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах
- Технологийн зөрчлийг бууруулах
- Түгээлтийн алдагдал бууруулах
- Боруулах ЦЭХ-ний хэмжээг нэмэгдүүлэх
- Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх ажлыг хийх төсөв тооцооллыг хийж гүйцэтгэсэн.

2023 онд хийгдэх их засварын 16, ТЗБАХ-ний 30 ажил дээр зургийн дагуу ажлын эзлэхүүнийг тодорхойлж, эрчим хүчний барилга угсралтын ажлын төсвийг “Эрчим хүчний үйлдвэр компаниудын засварын ажлын төсөв бодох аргачлал”-ын дагуу, барилга байгууламжийн засварыг “Монгол улсын БХБ-ын Сайдын 142 дугаар тушаалаар батлагдсан “Барилга сантехникийн ажлын төсвийн суурь норм”-ын үнэлгээ, БХБ-ын сайдын 2020 оны 30 тоот тушаалаар батлагдсан, “Барилгын төсөв зохиох /БНБД 81-95-12*2020/ дүрэм”, цалингийн зардлыг БХБ-ын сайдын 2020 оны 30 тоот тушаалын 3 дугаар хавсралт, машин механизмын зардлыг “ЗТБХБ-ын сайдын 2012 оны 18 дугаар тушаал/БД81-112-11/”, тээврийн зардлыг “ЗТХ-ийн Сайдын 2019-07-31-ний өдрийн 256 тоот тушаалын 4 дүгээр хавсралт”-аар батлагдсан жишиг тариф, орон нутгийн материалын тээврийн зайг 1986 оны “БАТУХ-ны 7 дугаар тогтоол, захиалагчийн өгсөн зай /км/”-г баримтлан тооцож байна.

Барилгын гүйцэтгэгч байгууллагын нэмэгдэл зардал, ашиг болон дайвар зардлуудыг “ЗТБХБСайдын 2012 оны 181 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт”, материалын үнийг “Барилгын мэдээлэл сэтгүүл”, барилгын үнэ ханшийн мэдээллийн сайтууд, харьяа салбаруудаас ирүүлсэн ажлын эзлэхүүнийг үндэслэн засварын инженерүүдийн гаргаж өгсөн зургийн дагуу зах зээл дээр худалдаалагдаж байгаа үнийн судалгаа ашиглан дундаж үнийг тогтоосон болно.

Нийт 2023 онд хийгдэх их засварын 16 төсөв хийснээс:

- Багануур ЦТСС-ын 7 төсөв, үүнээс барилгын засварын 2 төсөв
- Говьсүмбэр ЦТСС-ын 2 төсөв, үүнээс барилгын 1 төсөв
- Дорноговь ЦТСС-ын 4 төсөв, үүнээс барилгын 1 төсөв
- Дундговь ЦТСС-ын 2 төсөв
- Хэнтий ЦТСС-ын 3 төсөв, үүнээс барилгын 1 төсөв
- Компанийн хэсгийн 4 төсөв, үүнээс барилгын 4 төсөв байна.

ТЗБАХ-ний ажлын чиглэлээр 30 төсөв хийснээс

- Багануур ЦТСС-ын 7 төсөв
- Говьсүмбэр ЦТСС-ын 4 төсөв
- Дорноговь ЦТСС-ын 3 төсөв
- Дундговь ЦТСС-ын 7 төсөв
- Хэнтий ЦТСС-ын 9 төсөв тооцооллыг хийсэн байна.




Компанийн 2022 оны батлагдсан ТЭЗҮ, төлөвлөлтийн дагуу тодотголоор орсон нийт 17 ажлуудын төсвийн тооцооллыг хийж гүйцэтгэсэн байна.

- Багануур ЦТСС-ын 3 төсөв хийснээс их засварын 2, ТЗБАХ-ний 1
- Говьсүмбэр ЦТСС-ын 6 төсөв хийснээс их засварын 1, ТЗБАХ-ний 5
- Дундговь ЦТСС-ын 4 төсөв хийснээс их засварын 1, ТЗБАХ-ний 3
- Хэнтий ЦТСС-ын 4 төсөв хийснээс их засварын 1, ТЗБАХ-ний 3 ажлын тооцооллыг 2022 оны үнийн өсөлт, инфляцтай уялдуулан хийсэн байна.


Засварын ажлын талаар

2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд их засвар, техник зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын **88** нэр төрлийн ажлыг **5896.0** сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар **88** нэр төрлийн ажлыг 4742.3 сая төгрөгөөр хийж гүйцэтгэж, төлөвлөгөөний биелэлт **95.9%** байна.



	Нийт ажил (сая.төг)
■ 2022 оны төлөвлөгөө (сая.төг)	5896
■ Гүйцэтгэл (сая.төг)	4742.3

Засварын ажлын биелэлт (график)




Их засварын ажлын талаар

2022 онд **36** нэр төрлийн ажлыг 832.3 сая төгрөгөөр хийхээр төлөвлөж, 36 нэр төрлийн ажлыг 760.5 сая төгрөгөөр хийж, гүйцэтгэл 100%-тай байна. Их засвараас хийж гүйцэтгэсэн ажлуудаас дурдвал:

- Багануур салбар 6/0.4 кВ-ын КТПН-17 дэд өртөөний их биеийг бүрэн шинэчлэх ажлыг 19.3 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.

- Говьсүмбэр салбар Бор-Өндөр хэсгийн 45,47,48-р байрны щитний өрөөг орон сууцны зориулалтаар засварлах ажлыг 39.7 сая төгрөгөөр бүрэн хийж гүйцэтгэсэн.

- Дундговь салбарын Автограж, 6 кВ-ын ХХБ, аваарын дизелийн барилгуудын дээвэр засварлах ажлыг 107.2 сая төгрөгөөр бүрэн хийж гүйцэтгэсэн.




хийхээр төлөвлөж, 17 нэр төрлийн ажлыг 1995.9 сая төгрөгөөр хийж, гүйцэтгэл 100%-тай байна.

ТЗБАХ-ний ажлаар хийж гүйцэтгэсэн ажлын талаар товч дурдвал. Үүнд:

Дундговь салбарын 35/15 кВ-ын Хулд, 35/10 кВ-ын Дэлгэрцогт дэд станцын хашааг нэг маягийн зургийн дагуу шинэчлэх ажил 28.5 сая төгрөгийн төсөвт өртөгт багтаан бүрэн хийж гүйцэтгэсэн.



35/6 кВ-ын Зүүнбаян, 35/6 кВ-ын Төв дэд станцад диспетчерийн хяналтын систем холбох (Скада систем) ажлыг 144.9 сая төгрөгөөр бүрэн хийж гүйцэтгэсэн.



Дундговь салбар 35 кВ-ын Тэвшийнговь ЦДАШ-ын 4 км модон тулгуурыг төмөр бетон тулгуураар солих ТЗБАХ-ний ажлыг 133.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.



Багануур салбар 10 кВ-ын Жаргалтхаан-Дэлгэрхаан ЦДАШ-ын 25 км модон тулгуурыг төмөр бетон тулгуураар солих ТЗБАХ-ний ажлыг 310.3 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.



Говьсүмбэр салбар 35 кВ-ын Цагаандэлгэр ЦДАШ-ын 20 км модон тулгуурыг төмөр бетон тулгуураар солих ТЗБАХ-ний ажлыг 987.2 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.



Хэнтий салбар Сүмбэр сум 10 кВ-ын ЦДАШ шинээр угсарч, 6/0.4 кВ-ын ТП-73, 76, 78, 79, 81, 82, 83 КТП-74, 77 дэд өртөөнүүдийг 10 кВ-ын хүчдэлд шилжүүлэх ТЗБАХ-ний ажлыг 122.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.



Хэнтий салбар 35/10 кВ-ын Түмэнцогт дэд станцын 1000 кВА чадал бүхий Т-1 трансформаторыг 2500 кВА чадал бүхий трансформатороор солих ТЗБАХ-ний ажлыг 126.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.

Хөрөнгө оруулалтын ажлын талаар

Компанийн хэмжээнд 2022 онд нийт 24 нэр төрлийн 2765.3 сая төгрөгийн ажил үйлчилгээ, бараа материал худалдан авахаар төлөвлөж, 21 нэр төрлийн 1127.7 сая төгрөгийн бараа материал худалдан авсан гүйцэтгэл 87.7%-тай байна.

Хөрөнгө оруулалтын ажлын талаар

Д/д	Хэсэг, нэгж, дэд станц, шугамын нэр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төлөвлөгөө (сая.төг)	Гүйцэтгэл /НОАТ-гүй/ (сая.төгрөг)	Хэтрэлт, Хэмнэлт (сая.төгрөг)	Тайлбар	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8	9	10
Багануур салбар									
1	Тээвэр үйлчилгээний хэсэг	Шуурхай үйлчилгээний зориулалттай, тэвштэй автомашин	ком	1	130	130	0.0	Худалдан авалт хийгдсэн	100
2	РП-2 6 кВ ХХБ	UPS батарей байгууламж	ком	1	5	5	0.0	Бүрэн хийгдсэн	100
3	35/10 кВ Байдлаг дэд станц	UPS батарей	ш	18	5.4	5.4	0.0	Бүрэн хийгдсэн	100
4	Захиргааны хэсэг	35/10 кВ Байдлаг дэд станцын ажлын байр, ажлын зураг	ком	1	300.0	271.0	29.0	Барилгын ажил хийгдэж байна	80
5	Захиргааны хэсэг	ХҮТ-ийн хяналтын камер, яриа бичигчийн хамт	ком	1	1.9	1.9	0.0	Бүрэн хийгдсэн	100
Дүн					442.3	413.3	29.0		96.0
Говьсүмбэр салбар									



1	Тээвэр үйлчилгээний хэсэг	Шуурхай үйлчилгээний зориулалттай, тэвштэй автомашин	ш	1	130.0	130.0	0.0	Худалдан авалт хийгдсэн	100
2	Засвар, Бор-Өндөр, Шивээговь, ШҮ-ний хэсэг	МегаОмметр	ш	4	4.0	4.0	0.0	Бүрэн хийгдсэн	100
3	Бор-Өндөр хэсэг, Хангах үйл ажиллагааны хэсэг	Газардуулга хэмжих багаж /UNIT/	ш	2	1.0	1.0	0.0	Бүрэн хийгдсэн	100
4	Бор-Өндөр хэсэг	Цахилгаан үүсгүүр /380В/	ш	1	2.0	2.0	0.0	Худалдан авалт хийгдсэн	100
5	Захиргааны хэсэг	Скада систем хянах ухаалаг дэлгэц	ш	1	9.9	9.9	0.0	Худалдан авалт хийгдсэн	100
6	Тээвэр үйлчилгээний хэсэг	Кран (Zoomlion марктай дүйцэхүйц 25 тн даацтай)	ш	1	472.0	0.0	472.0	Гэрээ хийгдсэн	0
Дүн					618.9	146.9	472.0		83%
Дорноговь салбар									
1	Тээвэр үйлчилгээний хэсэг	Шуурхай үйлчилгээний зориулалттай, тэвштэй автомашин	ш	1	130.0	130.0	0.0	Худалдан авалт хийгдсэн	100%
2	Замын-Үүд хэсэг	Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн барилга	ш	1	523.2	345.4	177.8	Барилгын ажил он дамжин төлөвлөгөөний дагуу хийгдэж байна	80%
3	Захиргааны хэсэг	Скада систем хянах ухаалаг дэлгэц	ш	1	9.9	9.9	0.0	Бүрэн хийгдсэн	100%
4	Засварын хэсэг	Гагнуурын аппарат	ш	1	39.5	39.5	0.0	Гэрээ хийгдсэн	100%
5	Тоолуур хэмжүүрийн алба	1 ба 3 фазын тоолуур шалгах суурин төхөөрөмж засвар /HTDN-6H/	ш	1	20.0	19.6	0.4	Бүрэн хийгдсэн	100%
6	Хангах хэсэг	Орон сууцны тоолуур нэгтгэсэн щит	ком	1	115.7	108.3	7.4	Гэрээ хийгдсэн	100%
7	110/10 кВ Чөлөөт бүс дэд станц	Ажлын байрны халаалт болон шуурхай ажиллагааны	ком	1	17.1	17.1	0.0	Бүрэн хийгдсэн	100%



		холбооны төхөөрөмж							
Дүн					855.4	669.8	185.6		97.1%
Дундговь салбар									
1	Олгойнговь	35 кВ Тэвшийнговь, Дэлгэрцогт ЦДАШ-ыг төмөр бетон тулгуураар солих ажлын зураг хийлгэх	км	41	30.0	25.6	4.4	Бүрэн хийгдсэн	100%
2	Тээвэр үйлчилгээний хэсэг	Шуурхай үйлчилгээний зориулалттай, тэвштэй автомашин	ш	1	130.0	130.0	0.0	Худалдан авалт хийгдсэн	100%
3	35/15 кВ Хулд дэд станц	6 кВА-ын UPS батарей байгууламж	ш	1	9.0	9.0	0.0	Бүрэн хийгдсэн	100%
4	Захиргааны хэсэг	Скада систем хянах ухаалаг дэлгэц	ш	1	9.9	9.9	0.0	Худалдан авалт хийгдсэн	100%
Дүн					178.9	174.5	4.4		100%
Хэнтий салбар									
1	Тээвэр үйлчилгээний хэсэг	Шуурхай үйлчилгээний зориулалттай, тэвштэй автомашин	ш	1	130	130	0.0	Худалдан авалт хийгдсэн	100%
2	Захиргааны хэсэг	Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн барилгын ажлын зураг	ш	1	50	0.0	50.0	Гэрээ хийгдсэн	0%
3	Хангах хэсэг	Орон сууцны тоолуур нэгтгэсэн щит	ком	1	64.4	57.0	7.4	Бүрэн хийгдсэн	100%
4	10 кВ Хурх АШ	Модон тулгуурыг төмөр бетон тулгуураар солих ажлын зураг хийлгэх	Хэм жих нэгж	1	20.0	0.0	20.0	Гэрээ хийгдсэн. Зурагдаж байна.	0%
Дүн					264.4	187.0	77.4		50.0%
Төв компани									
1	Засвар угсралт, РХА-ийн алба	Электрон МегаОмметр /victor-3125/	ш	1	3.0	3.0	0.0	Бүрэн хийгдсэн	100%
2		DigSILENT PowerFactory програм сүүлийн хувилбар	ш	3	161.0	161.0	0.0	Бүрэн хийгдсэн	100%
3	Засвар угсралт, РХА-ийн алба	Ялтсан бойлуур /GK23*40H/	ш	40	20.0	18.5	1.5	Бүрэн хийгдсэн	100%



4	Мэдээлэл технологийн алба	35/10 кВ, 35/6 кВ, 35/0.4 кВ дэд станцуудыг камержуулах	ш	13	43.3	43.3	0.0	Худалдан авалт хийгдсэн	100%
5	Тоолуур хэмжүүрийн алба	Тоолуур шалгах зөөврийн төхөөрөмжийн хүчдэлийн үзүүр тусад нь холбох зориулалт бүхий хүчдэлийн трансформатор	ш	1	2.0	2.0	0.0	Бүрэн хийгдсэн	100%
6		Дэд станцуудын мэдээллийг SCADA системд холбох төхөөрөмж, дагалдах хэрэгсэлийн хамт	ш	18	14.0	14.0	0.0	Худалдан авалт хийгдсэн	100%
7	Мэдээлэл технологийн алба	Ухаалаг тоолуур хэрэгжиж байгаатай холбогдуулан компьютер, мэдээлэл технологийн тоног төхөөрөмж бусад дагалдах хэрэгслийн хамт	ком	1	153.5	143.8	9.7	Худалдан авалт хийгдсэн	100%
8	Тээвэр үйлчилгээний алба	Cat 426F2 ухагч шанаганы базагч	ком	1	7.5	8.2	-0.7	Бүрэн хийгдсэн	100%
9	Тээвэр үйлчилгээний хэсэг	Цайны газрын халаагуур, тос баригч	ком	1	1.0	0.5	0.5	Бүрэн хийгдсэн	100%
Дүн					405.4	394.3	11.0		100%

5.4. Цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангах

2022 онд компанийн эзэмшил, үйлчлэх хүрээний цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай ханган ажиллах, технологийн үйл ажиллагаандаа инновац дээр суурилсан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх замаар түгээлтийн алдагдлыг бууруулж, борлуулах ЦЭХ-ний хэмжээ, орлогыг нэмэгдүүлж, техник зохион байгуулалтын арга хэмжээний болоод их, урсгал засвар, хөрөнгө оруулалтын ажлуудын үр ашгийг дээшлүүлэх зорилго тавьж ажиллалаа.

Дээрх зорилтын хүрээнд 35 кВ-ын ЦДАШ-ын дамжуулагчийн хөндлөн огтлолын талбайг нэмэгдүүлж, 0.4 кВ-ын АШ-ын дамжуулагчийг бүрээстэй дамжуулагчаар солих, мөн модон тулгуур, төмөр бетон хөл бүхий 10 кВ, 6 кВ, 0.4 кВ-ын АШ-уудын шинэчлэн байгаль экологид хоргүй төмөр бетон тулгууртай болгох, АТП болон ХБ-уудын цахилгаан тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх, тосон таслууруудыг вакуум таслуураар солих зэрэг их,



урсгал засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажлуудыг хийж гүйцэтгэснээр Монгол улсын MNS (IEC) 38:2001 хүчдэлийн түвшний стандартын шаардлагыг бүрэн хангаж байна.

Ашиглалтын түвшин муу, насжилт болон эрсдэлийн зэрэг өндөртэй, тасралт, саатал их гардаг 35 кВ-ын Цагаандэлгэр, Тэвшийнговь ЦДАШ-ын модон тулгуур, төмөр бетон хөл бүхий хараацай хэлбэрийн тулгуурыг төмөр бетон тулгуураар солих ажлыг хийж гүйцэтгэснээр тасралт, технологийн зөрчил, дутуу түгээсэн цахилгаан эрчим хүчний хэмжээ буурч, ЦЭХ-ний өндөр хэрэглээтэй томоохон хэрэглэгчдийг чанар стандартын шаардлага хангасан ЦЭХ-ээр тасралтгүй, найдвартай хангаж ажиллах техникийн боломжоор хангагдлаа.

2020-2030 оны компанийн цахилгаан түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх бодлого, зорилтуудын хүрээнд нам хүчдэлийн болон дунд хүчдэлийн хуваарилах цахилгаан шугам сүлжээг шинэчлэх, аюулгүй, найдвартай ажиллагааг дээшлүүлэх, түгээлтийн алдагдлыг бууруулах, цахилгаан эрчим хүчний чанарын үзүүлэлтүүдийг стандартын түвшинд барьж ажиллах, хөрөнгө оруулалтын болоод техник эдийн засгийн үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлэхээр ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасны дагуу 2022 онд 0.4 кВ, 6 кВ, 10 кВ-ын хүчдлийн түвшний ЦДАШ-уудын шинэчлэлийн 14 нэр төрлийн ажлыг 1762.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн нь нийт ИЗ, ТЗБАХ, ХО-ын ажлын 37.1 %-ийг эзэлж байна.

Мөн нам хүчдэлийн ил ба хаалттай хуваарилах байгууламжууд, тэдгээрийн тоноглолын ашиглалтын түвшнийг сайжруулах, солих шинэчлэх ажлуудыг 89.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна. Эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэснээр Эрчим хүчний нэгдсэн сүлжээний дүрмийн 2.2.2.3 дугаар заалтын дагуу эцсийн хэрэглэгч дээрх хүчдэлийн түвшин хэвийн хэмжээнд хүргэж, хэрэглэгчээс ирсэн гомдол санал буурсан үзүүлэлттэй байна.

5.5. Урсгал засварын ажлын талаар

2022 оны төлөвлөгөөгөөр 669 нэр төрлийн ажлыг 272.1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 669 ажлыг 100% гүйцэтгэсэн.

Хүснэгт 9. Урсгал засварын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Зардлын төрөл	Салбар хэсгийн нэр								
		Багануур			Говьсүмбэр			Дорноговь		
		тоо	Төл /Мян төг/	Гүйцэтгэл	тоо	Төл /Мян төг/	Гүйцэтгэл	тоо	Төл /Мян төг/	Гүйцэтгэл
1	Анхдагч хэлхээний тоноглолын засвар	6	2,851.5	3,822.3	4	3,332.5	3,118.5	4	8,425.1	8,060.0
2	Аяндын улиралд бэлтгэж хийх ажил	3	980.0	786.6	8	489.8	391.6	1	816.0	193.0
3	Өвлийн бэлтгэл ажил	3	4,589.2	4,117.7	2	3,387.0	3,746.6	0	0.0	153.9
4	Ажлын багаж хэрэгслийн	28	8,598.0	9,969.0	30	9,120.0	9,512.3	0	0.0	1,577.1



	зардлын төлөвлөгөө									
5	РХА-ийн их ба урсгал засвар	14	282.7	340.2	18	1,766.8	1,839.5	0	0.0	590.0
6	Хэмжилт туршилтын ажил	2	945.8	215.0	9	79.6	68.6	0	0.0	0.0
7	Ашиглалтын түвшин дээшлүүлэх ажил	7	6,050.0	5,783.0	7	6,688.0	6,998.9	10	6,050.5	5,248.6
8	Борлуулалтын ашиглалтын түвшин дээшлүүлэх ажлын зардал	4	8,923.5	7,141.7	5	3,039.3	3,031.3	5	8,233.3	3,955.4
9	Ажлын байрны тохижилтын зардал	4	3,400.0	5,205.4	4	5,846.5	6,180.7	4	2,700.0	2,161.1
10	Ажлын байрны цэвэрлэгээний материалын зардал	21	3,349.2	4,536.3	23	4,812.4	4,481.3	57	3,642.2	2,969.8
11	Шатах тослох материалын зардал	11	5,055.1	5,589.9	7	5,043.0	5,112.0	6	4,263.0	3,050.5
12	Төлөвлөгөөт бус ажил	0	0.0	7,098.8	0	0.0	17,059.3	0	0.0	6,236.0
	Нийт дүн	103	45145.0	54,606.0	117	43,629.9	69,066.1	87	34,130.1	34,195.4

№	Зардлын төрөл	Салбар хэсгийн нэр								
		Дундговь			Хэнтий			Компани		
		тоо	Төл /Мян төг/	Гүйцэтгэл	тоо	Төл /Мян төг/	Гүйцэтгэл	тоо	Төл /Мян төг/	Гүйцэтгэл
1	Анхдагч хэлхээний тоноглолын засвар	8	8,423.0	5,764.9	1	6,735.0	13,856.7	0	0.0	0.0
2	Аянгын улиралд бэлтгэж хийх ажил	2	1,530.0	2,477.3	1	750.0	392.5	0	0.0	0.0
3	Өвлийн бэлтгэл ажил	1	450.0	430.0	8	1,360.0	1,236.4	0	0.0	0.0
4	Ажлын багаж хэрэгслийн зардлын төлөвлөгөө	17	5,400.0	4,520.4	11	2,165.0	5,741.8	29	11,089.8	10,673.5
5	РХА-ийн их ба урсгал засвар	7	91.2	529.6	9	3,245.2	2,483.7	0	0.0	0.0
6	Хэмжилт туршилтын ажил	1	635.0	488.5	11	1,164.0	217.7	1	180.5	180.5

“БЗӨБЦТС ТӨХК”-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



7	Ашиглалтын түвшин дээшлүүлэх ажил	15	6,461.8	7,312.8	13	7,387.8	10,118.3	4	27,603.1	27,603.1
8	Борлуулалтын ашиглалтын түвшин дээшлүүлэх ажлын зардал	11	6,461.8	6,970.7	7	5,998.6	5,291.6	0	0.0	0.0
9	Ажлын байрны тохижилтын зардал	3	10,246.0	10,998.5	14	2,177.0	4,038.1	12	6,326.5	6,326.5
10	Ажлын байрны цэвэрлэгээний материалын зардал	35	2,862.9	2,727.2	23	2,814.0	3,108.4	83	9,294.1	8,557.4
11	Шатах тослох материалын зардал	8	4,721.1	3,430.2	7	4,896.0	7,660.9	20	8,348.8	9,485.9
12	Төлөвлөгөөт бус ажил	0	0.0	0.0	0	0.0	0.0	0	0.0	409.3
	Нийт дүн	108	47,718.4	45,650.0	105	38,692.5	54,146.0	149	62,842.7	59,045.6

№	Зардлын төрөл	Бүгд дүн		Хувь	
		тоо	Төл /Мян төг/	Гүйцэтгэл	Хувь
1	Анхдагч хэлхээний тоноглолын засвар	23	29,767	34,622	100.0
2	Аянгын улиралд бэлтгэх хийх ажил	15	4,566	4,241	100.0
3	Өвлийн бэлтгэл ажил	14	9,786	9,685	100.0
4	Ажлын багаж хэрэгслийн зардлын төлөвлөгөө	115	36,373	41,994	100.0
5	РХА-ийн их ба урсгал засвар	48	5,386	5,783	100.0
6	Хэмжилт туршилтын ажил	24	3,005	1,170	100.0
7	Ашиглалтын түвшин дээшлүүлэх ажил	56	60,241	63,065	100.0
8	Борлуулалтын ашиглалтын түвшин дээшлүүлэх ажлын зардал	32	32,656	26,391	100.0
9	Ажлын байрны тохижилтын зардал	41	30,696	34,910	100.0
10	Ажлын байрны цэвэрлэгээний материалын зардал	242	26,775	26,380	100.0



11	Шатах тослох материалын зардал	59	32,327	34,329	100.0
12	Төлөвлөгөөт бус ажил	0	0	30,803	
	Нийт дүн	669	272,158.7	316,709.3	100.0

5.6. Үр өгөөжийн тооцоо

1.Тэвшийнговь 35 кВ-ын ЦДАШ-ын модон тулгуурын өнөөгийн байдал болон шинэчлэлийн ажил хийснээр гарах үр өгөөжийн тооцоо:

Тэвшийнговь 35кВ-ын ЦДАШ нь 1989 онд баригдсан төмөр бетон хөл бүхий модон тулгууртай. Энэ ЦДАШ-аас Дэлгэрцогт, Дэрэн, Адаацаг, Сүм хөх бүрд, Дэлгэрийн чойрын хийд зэрэг сум суурингийн нийт ҮААН-ийн 114, ахуйн 550-н хэрэглэгчид тэжээгддэг. Жилд 2.5 сая.кВт.ц ЦЭХ дамжуулдаг бөгөөд 2017 онд Сүм хөх бүрд аялал жуулчлалын төв нь 160 кВт.ц-ын суурилагдсан хүчин чадлаар хэрэглээгээ нэмэгдүүлээд байна.

2022 оны байдлаар тус АШ гэмтсэнээр гарсан ЭЗ-ийн хохирол алдагдал

Д/д	Хүчин зүйлийн нөлөө	Тасралт гэмтлээс үүдэн гарах ЭЗ-ийн хохирол алдагдал	Тус АШ-г шинэчлэн сольсноор
1	2	3	4
1	Тасралтын тоо	6	0
2	Тасралтын нийт хугацаа /цаг/	18	0
3	Дутуу түгээсэн ЦЭХ /кВт.ц/	7192	0
4	ЦЭХ-р тасалдсан хэрэглэгчдийн тоо	664	0
5	Хэрэглэгчдээс ирсэн гомдлын тоо	26	0
6	ЦЭХ-р тасалдсан I, II зэргийн хэрэглэгчдийн тоо	12	0
7	Гэмтлийг устгахад зарцуулагдсан эд материал, шатахууны зардал /төг/	851200	0
8	Гэмтлийг устгахад зарцуулагдсан хүн хүчний болон томилолтын зардал /төг/	1058000	0

АШ гэмтэлд гарсан ЭЗ-ийн хохирол алдагдал, олон жилийн дунджаар /5 жилийн дундаж/

Д/д	Хүчин зүйлийн нөлөө	Тасралт гэмтлээс үүдэн гарах ЭЗ-ийн хохирол алдагдал
1	2	3
1	Тасралтын тоо	13
2	Тасралтын нийт хугацаа /цаг/	150
3	Дутуу түгээсэн ЦЭХ /кВт.ц/	59932
4	ЦЭХ-р тасалдсан хэрэглэгчдийн тоо	664
5	Хэрэглэгчдээс ирсэн гомдлын тоо	25
6	ЦЭХ-р тасалдсан I, II зэргийн хэрэглэгчдийн тоо	9
7	Гэмтлийг устгахад зарцуулагдсан эд материал, шатахууны зардал /төг/	3688533
8	Гэмтлийг устгахад зарцуулагдсан хүн хүчний болон томилолтын зардал /төг/	3356166



Гарах үр дүн.

1. Эдийн засгийн хувьд:

Тэвхийнговь 35кВ-ын ЦДАШ нь Дэлгэрцогт хүртэл нийт 41.5км бөгөөд үүнээс одоо шинэчлэл хийгдээгүй шугамын модон тулгуурыг 1 жилийн хугацаанд 100% шинэчлэнэ гэж тооцвол 1,4 тэрбум төгрөгийн зардал гарах буюу энэ зардал нь Дундговь ЦТСС-ын 4 жилийн Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын зардалтай тэнцэх юм. Иймд тус ЦДАШ-ын модон тулгуурыг 100% ашиглах боломжгүй болохоос өмнө шинэчлэх ажлыг 5-7 жилийн хугацаанд багтаан гүйцэтгэх нь эдийн засгийн хувьд хүндрэл багатай байх болно.

2. ХАБЭАхуйн хувьд:

Тус 35кВ-ын ЦДАШ нь 1987 онд ашиглалтад орсон. Ашиглалтын хугацаа дууссан, эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. Шинэчлэл хийснээр эрсдэлгүй болно. Болзошгүй ослоос урьдчилан сэргийлж чадна.

3. Чанар, Стандартын хувьд

ЦЭХ-ний чанарын MNS38:2001 стандартын дагуу чанартай ЦЭХ-р хэрэглэгчдийг хангах боломтой болно.

2.Багануур салбарын үйлчлэх хүрээний 10 кВ-ын Дэлгэрхаан-Жаргалтхаан ЦДАШ-ын шинэчлэлийн ажил хийгдсэнээр гарах үр өгөөжийн тооцоо

Жаргалтхаан дэд станцын яч№5 10 кВ-ын ДХ ЦДАШ нь 1983 онд ашиглалтад орсон ба модон тулгуурууд өмхөрсөн, дэгээ изолятор мултрах нөхцөл байдал үүссэн, эдгээр гэмтлүүдээс үүдэн тасралтын тоо, технологийн зөрчил үүсэх үндсэн шалтгаан болоод байна. Тус шугам нь үйлчлэх цэгээс 175 км байрладаг ба гэмтлийг устгахад хугацаа зарцуулалт өндөр байгаа нь хэрэглэгчдийн ЦЭХ-ийг удаан хугацаагаар хязгаарлах, үүнээс үүдэн борлуулалтын орлого багасах, технологийн горим зөрчигдөж байгаа билээ.

10 кВ-ын Дэлгэрхаан-Жаргалтхаан ЦДАШ-ын шинэчлэлийн ажлын үр өгөөжийн тооцоо

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	Өөрчлөлт
1	2	3	4	5	6
1	Худалдан авах ЦЭХ	Мян.кВт.ц	442.4	465	22.6
2	Түгээлтийн алдагдал (биет)	Мян.кВт.ц	-31.4	0	0
3	Түгээлтийн алдагдал (хувь)	%	-7.1	0	0
4	Борлуулсан ЦЭХ	Мян.кВт.ц	473.9	465	8.9
5	Борлуулалтын орлого	Мян.төг	78976.2	77469	1507.2
6	Борлуулалтын дундаж тариф	Төг/кВт.ц	166.66	166.6	0
7	Хэрэглэгчийн тоо	ш	349	349	0
8	Айл өрх	ш	295	295	0
9	ААНБ	ш	54	54	0

10 кВ-ын Жаргалтхаан ЦДАШ-ын шинэчлэлийн засварын ажлыг хийж гүйцэтгэсэнээр:

- Тасралтын тоо буурна
- Технологийн зөрчлөөс урьдчилан сэргийлнэ
- Урсгал зардал хэмнэх
- ЦЭХ-ний чанарын үзүүлэлтийг хангаж ажиллах
- Болзошгүй аюул эрсдэл арилах



- Ашиглалтын зардал багасах
- Борлуулалтын орлого нэмэгдэх
- Дутуу түгээсэн ЦЭХ буурна.

5.7. Горим стандартчиллын талаар

Цахилгааны бодит хэрэглээ, олон жилийн судалгааг үндэслэн худалдан авсан цахилгаан эрчим хүчний хэмжээг техникийн найдвартай ажиллагаа, хамгийн бага өртгийн шалгуур болгон авч болох нөөц чадалд тулгуурлан горим схемийг цаг уурын нөхцөл, технологийн шаардлага, аваарын нөхцөл байдал, системийн тогтворжилтыг тооцон оновчтой боловсруулан, их бага ачаалал, сар улирал жилийн чадал, энергийн баланс гарган, цахилгааны хэрэглээний хэтийн төлөв, алдагдлыг тодорхойлж горим ажиллагаанд өдөр тутам тасралтгүй хяналт тавьж ажиллаж байна.

“Диспетчерийн Үндэсний Төв” ХХК-иас санал ирүүлэх тухай албан бичгийн дагуу 2022 оны зуны бага ачааллын үеийн горимд шаардлагатай үзүүлэлтүүдээр тооцоо хийж, 2022 оны зуны горим ажиллагааны саналыг боловсруулж “ЦДҮС” ТӨХК-ийн ЗӨБ-ийн салбар, Говийн бүсийн салбарын горимын инженерүүдтэй тооцоо нийлж “ДҮТ” ТӨХХК-д хүргүүлж мөрдөн ажилласан байна.

2022 оны зуны бага ачааллын үед мөрдөж ажиллах шугам тоноглолын горим ажиллагааг боловсруулж батлуулан харьяа салбарууд руу хүргүүлж мөрдөж ажилласан.

Зуны бага ачааллын талаар

“Диспетчерийн Үндэсний Төв” ТӨХХК-ийн 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хяналт хэмжилт хийх тухай 02/778 дугаартай албан бичгийн дагуу тус компанийн ТҮАХБХ-ээс хяналт хэмжилт зохион байгуулах тухай албан бичгийг харьяа салбаруудад 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хүргүүлсэн. Харьяа салбаруудын ТҮАХ ерөнхий инженерийн баталсан хуваарийн дагуу 2022 оны зуны бага ачааллын хэмжилтийг тус оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 04⁰⁰, 12⁰⁰, 15⁰⁰, 19⁰⁰ цагуудад компанийн түгээх болон нам хүчдэлийн хуваарилах сүлжээ, хэрэглэгчдийн эзэмшлийн дэд станцуудад хийж гүйцэтгэлээ.

Компанийн эзэмшлийн 110/35/10 кВ, 110/10 кВ, 35/10 кВ, 35/6 кВ, 35/0.4 кВ-ийн 32, хэрэглэгчийн эзэмшлийн 29, нийт 61 дэд станц хамрагдсан байна.


15/0.4 кВ, 10/0.4 кВ, 6/0.4 кВ-ын компанийн эзэмшлийн 452, хэрэглэгчийн эзэмшлийн 351, нийт 803 хаалттай трансформаторын хуваарилах байгууламжууд, агаарын дэд станцуудад хяналт хэмжилтийг явуулав.

Хэмжилтэд 0.4 кВ, 6 кВ, 10 кВ-ын амперклевц, вольтметр, щитны хэмжүүрүүд, ВАФ-85, тестер, микропроцессорын реле, 193 цэгт ЦЭХ-ний ухаалаг тоолууруудын НЕС системийн өгөгдлүүдийг ашигласан.

Хэмжилт хийсэн цэгүүдэд хэмжилтийн дүн, параметруудийг эмхэтгэж, манай компанийн түгээх сүлжээгээр урсан өнгөрсөн чадлыг хэмжилт хийсэн өдрөөр буюу 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хэмжилт хийгдсэн цаг тус бүрээр хүснэгт.1 болон график. 1-ээр харуулбал:

Түгээх сүлжээгээр урсан өнгөрсөн чадал /кВт/

Үзүүлэлт	2021 05 цаг	2022 04 цаг	2021 11 цаг	2022 12 цаг	2021 15 цаг	2022 15 цаг	2021 22 цаг	2022 19 цаг
Чадал /кВт/	62804.6	54210	76470.7	55685	82013	58873	74635.3	52053




2021, 2022 оны чадлын урсгалын харьцуулалтын зөрүү	15.233 МВт	21.861 МВт	24 МВт	23.543 МВт
	24.25 % буурсан	28.58 % буурсан	29.26 % буурсан	31.5 % буурсан

2021, 2022 оны чадлын урсгалыг харьцуулсан нь

Зургаас харахад харахад компанийн түгээх болон нам хүчдэлийн хуваарилах сүлжээний хоногийн ачааллын графикаас урсах чадлын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэмжилт хийсэн цагуудад 24.25 – 31.5 % буюу 15.23 – 24 МВт чадлаар буурсан дүнтэй байна.


Дорноговь ЦТС салбарын дэд станцууд (график)



Дорноговь ЦТС салбарын 8 дэд станцаас 2 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс 250.3 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 5 дэд станцын ачаалал 535.1 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй, 110/10 кВ Чөлөөт бүс дэд станц ачаалалгүй байна.

Тус салбарын хэмжилтэд хамрагдсан 35 кВ-ын 8 дэд станцын хувьд өмнөх оны мөн үеэс ачааллын хэмжээ 284.8 кВт чадлаар буурсан, нийт хүчний трансформаторуудын суурилагдсан хүчин чадал 49915 кВА байгаагаас 20.87 % буюу 10421 кВА чадлыг ашиглаж байна.


Дундговь ЦТС салбарын дэд станцууд (график)






Дундговь ЦТС салбарын 35 кВ хүчдэлийн түвшний 6 дэд станцаас 2 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс 416 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 3 дэд станц 191 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй, 1 дэд станц өмнөх оны мөн үетэй адил хэмжээгээр ачаалагдсан байна. Тус салбарын хэмжилтэд хамрагдсан 35 кВ-ын 6 дэд станцын хувьд өмнөх оны мөн үеэс 225 кВт чадлын өссөн, нийт трансформаторуудын суурилагдсан хүчин чадал 12800 кВА байгаагаас 24.7 % буюу 3161 кВт чадлыг ЦЭХ хэрэглэгчдэд түгээж байна.

Хэнтий ЦТС салбарын дэд станцууд (график)



Хэнтий ЦТС салбарын 35 кВ-ын хүчдэлийн түвшний 8 дэд станцаас 4 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс 230.8 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 4 дэд станц 254.4 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй, 110/35/10 кВ Бэрх дэд станц 13.5 %-ийн ачаалалтай байна. Тус салбарын хэмжилтэд хамрагдсан 35 кВ-ын 8 дэд станцын хувьд өмнөх оны мөн үеэс ачааллын хэмжээ 23.6 кВт чадлын бууралттай, нийт хүчний трансформаторуудын суурилагдсан хүчин чадал 17230 кВА байгаагаас 39.4 % буюу 6788.8 кВт чадлыг ЦЭХ хэрэглэгчдэд түгээж байна.


Багануур ЦТС салбарын дэд станцууд (график)



Багануур ЦТС салбарын 8 дэд станцаас 5 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс 599 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 3 дэд станц 574.5 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй

байна. Тус салбарын хэмжилтэд хамрагдсан 8 дэд станцын хувьд өмнөх оны мөн үеэс ачааллын хэмжээ 24.5 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй байна. Тус салбарын эзэмшлийн 35 кВ-ын 4 дэд станцуудын нийлбэр суурилагдсан хүчин чадал 13100 кВА чадал байгаагаас 5.7 % буюу 746.4 кВт чадлыг ЦЭХ хэрэглэгчдэд түгээж байна.

Говьсүмбэр ЦТС салбарын дэд станцууд (график)



Говьсүмбэр ЦТС салбарын 35 кВ-ын хүчдэлийн түвшний 8 дэд станцаас 2 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс 306.8 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 6 дэд станц 1252.7 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй байна. Тус салбарын хэмжээнд хэмжилтэд хамрагдсан 35 кВ-ын 8 дэд станцын хувьд өмнөх оны мөн үеэс 945.9 кВт чадлын буурсан үзүүлэлттэй гарч байна. Тус салбарын эзэмшлийн нийт трансформаторуудын суурилагдсан хүчин чадал 32750 кВА байгаагаас 6.84 % буюу 2243 кВт чадлыг ЦЭХ хэрэглэгчдэд түгээж байна.

Компанийн хэмжээнд: Хэмжилтэд хамрагдсан харьяа салбаруудын 35 кВ-ын дэд станцуудын нийлбэр ачааллын хэмжилтийг тооцож үзвэл нийт 32 дэд станцаас 11 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс 1802.9 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 21 дэд станцын ачаалал 2807.8 кВт чадлаар буурсан дүнтэй байна. Компанийн хэмжээнд 35 кВ-ын хэмжилтэнд дэд станцуудын хувьд 1004.9 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй байна.

Д/д	Салбар	Дэд станцын тоо	Суурилагдсан хүчин чадал, /кВА/	Ашиглагдаж байгаа хүчин чадал /кВт/	Ачаалал өссөн дэд станцын		Ачаалал буурсан дэд станцын	
					тоо	нийлбэр дүн /кВА/	тоо	нийлбэр дүн /кВА/
1	2	3	4	5	6	7	8	9
1	Дорноговь	6	49915	10421	2	250.3	6	535.1
2	Дундговь	6	12800	3161	2	416	3	191
3	Хэнтий	8	17230	6788.8	4	230.8	4	254.4
4	Багануур	4	13100	746.4	5	599	3	574.5
5	Говьсүмбэр	8	32750	2243	2	306.8	6	1252.8
БҮГД		32	125795	23360	11	1802.9	21	2807.8


Хэмжилтийн үр дүн 6-10 кВ хүчдэлийн түвшинд:



Компанийн харьяа салбаруудын 452 агаарын болон хаалттай дэд станцуудын хүчний трансформаторын ачаалагдсан байдлыг харууллаа.

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн сүлжээний хэмжээнд дэд өртөөнүүдийн ачаалагдсан байдал

Д/д	Салбар	Хэмжих нэгж	Ачаалагдсан хувь					Дүн, ш
			20-оос доош %	20-50 %	50-80 %	80-100 %	100-аас дээш %	
1	2	3	4	5	6	7	8	9
1	Багануур	ш	52	32	3	0	0	87
		%	59.77	36.78	3.44	0	0	100
2	Говьсүмбэр	ш	50	20	0	0	0	70
		%	71.42	28.57	0	0	0	100
3	Дорноговь	ш	68	36	1	0	0	105
		%	64.76	34.28	0.95	0	0	100
4	Дундговь	ш	49	48	3	0	0	100
		%	49	48	3	0	0	100
5	Хэнтий	ш	67	62	4	0	0	133
		%	5037	46.61	3	0	0	100
6	Компани	ш	286	198	11	0	0	495
		%	57.77	40	2.22	0	0	100




Нийт трансформаторуудын ачаалагдсан хувь (график)

Хүчний трансформаторуудын ачаалагдсан байдлыг харахад:

20 хувиас доош ачаалалтай трансформатор нийт трансформаторын 57.77 хувийг, 20-50 хувийн ачаалалтай трансформатор нийт трансформаторын 40 хувийг, 50-80 хувийн ачаалалтай трансформатор нийт трансформаторын 2.22 хувийг тус тус эзэлж байна.


Нийт дэд өртөөнүүдийн хүчний трансформаторуудын ажиллаж буй горимыг хувиар илэрхийлж харууллаа.





Дунд хүчдэлийн түвшний хүчний трансформаторуудын ачаалагдсан байдлыг ачааллын хувь, харьяа салбар тус бүрээр харууллаа.

20 хувь хүртэлх ачаалалтай ажиллаж байгаа трансформаторууд салбар тус бүрээр



Хэнтий ЦТС салбар нийт 133 ш дэд өртөөнөөс 67 ш дэд өртөө 20% хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 20% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 23.42 %-ийг эзэлж байна.


Дундговь ЦТС салбар нийт 100 ш дэд өртөөнөөс 49 ш дэд өртөө 20 % хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 20 % хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 17.13 %-ийг эзэлж байна.

Дорноговь ЦТС салбар нийт 105 ш дэд өртөөнөөс 68 ш дэд өртөө 20% хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 20% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 23.77 %-ийг эзэлж байна.

Говьсүмбэр ЦТС салбар нийт 87 ш дэд өртөөнөөс 52 ш дэд өртөө 20% хүртэлх ажиллаж ачаалалтай байна. Энэ нь компанийн хэмжээний 20% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 17.48 %-ийг эзэлж байна.

Багануур ЦТС салбар нийт 87 ш дэд өртөөнөөс 52 ш дэд өртөө 20% хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 20% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 18.18 %-ийг эзэлж байна.

20-50% ачаалалтай ажиллаж байгаа трансформаторууд салбар тус бүрээр





Хэнтий ЦТС салбар нийт 133 ш дэд өртөөнөөс 62 ш дэд өртөө 20-50% хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 20-50% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 31.31 %-ийг эзэлж байна.


Дундговь ЦТС салбар нийт 100 ш дэд өртөөнөөс 48 ш дэд өртөө 20-50 % хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 20-50 % хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 24.24 %-ийг эзэлж байна.

Дорноговь ЦТС салбар нийт 105 ш дэд өртөөнөөс 36 ш дэд өртөө 20-50% хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 20-50% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 18.18 %-ийг эзэлж байна.

Говьсүмбэр ЦТС салбар нийт 70 ш дэд өртөөнөөс 20 ш дэд өртөө 20-50% хүртэлх ажиллаж ачаалалтай байна. Энэ нь компанийн хэмжээний 20-50% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 10.10 %-ийг эзэлж байна.

Багануур ЦТС салбар нийт 87 ш дэд өртөөнөөс 32 ш дэд өртөө 20% хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 20% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 16.16 %-ийг эзэлж байна.

50-80% ачаалалтай ажиллаж байгаа трансформаторууд салбар тус бүрээр



Хэнтий ЦТС салбар нийт 133 ш дэд өртөөнөөс 4 ш дэд өртөө 50-80% хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 50-80% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 36.36 %-ийг эзэлж байна.

Дундговь ЦТС салбар нийт 100 ш дэд өртөөнөөс 3 ш дэд өртөө 50-80 % хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 50-80 % хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 27.27 %-ийг эзэлж байна.

Дорноговь ЦТС салбар нийт 105 ш дэд өртөөнөөс 1 ш дэд өртөө 50-80% хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 50-80% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 9.09 %-ийг эзэлж байна.

Говьсүмбэр ЦТС салбар нийт 70 ш дэд өртөөнөөс 50-80% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүд байхгүй байна.

Багануур ЦТС салбар нийт 87 ш дэд өртөөнөөс 3 ш дэд өртөө 50-80% хүртэлх ачаалалтай ажиллаж байна. Энэ нь компанийн хэмжээний 50-80% хүртэлх ачаалалтай байгаа дэд өртөөнүүдийн 27.27 %-ийг эзэлж байна.

80-100%, 100 %-иас дээш ачаалалтай ажиллаж байгаа трансформаторууд харъяа салбаруудад байхгүй байна.

Түгээх сүлжээний горим ажиллагааг тооцоолон хүндрэлтэй нөхцөл байдлаас гарах, хүчдэлийн түвшнийг нэмэгдүүлэх шат дараалсан техник зохион байгуулалтын арга



хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа бөгөөд хэт ачаалалд орсон болон хэт ачаалагдах магадлалтай өндөр ачаалалтай трансформаторуудыг чадлыг нэмэгдүүлэн сольж тавих, хүчдэлийн уналт болон өсөлт үүсэж байгаа цэгүүд дээр дахин хэмжилт хийх, шаардлагатай цэгүүдэд фазын тэнцүүлэлт хийх, хүчдэлийн тохируулга болох анцаф болон РПН-ээр хүчдэлийг өсгөх, бууруулахаар нэгдсэн сүлжээний дүрэмд заасан зөвшөөрөгдөх хэмжээнд барьж ажиллахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.

2022-2023 оны өвлийн их ачааллын хяналт хэмжилтийн ажлын талаар

“Диспетчерийн Үндэсний Төв” ТӨХК-ийн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хяналт хэмжилт хийх тухай 02/1851 дугаартай албан бичгийн дагуу тус компанийн ТҮАХБХ-ээс хяналт хэмжилт зохион байгуулах тухай албан бичгийг харьяа салбаруудад 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлсэн. Харьяа салбаруудын ТҮАХ ерөнхий инженерийн баталсан хуваарийн дагуу 2022-2023 оны өвлийн их ачааллын хэмжилтийг тус оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 04⁰⁰, 11⁰⁰, 19⁰⁰, 23⁰⁰ цагуудад компанийн түгээх болон нам хүчдэлийн хуваарилах сүлжээ, хэрэглэгчдийн эзэмшлийн дэд станцуудад хийж гүйцэтгэлээ.

Хэмжилтэд хамрагдсан дэд станц, хэмжих хэрэгслийн талаар:

Компанийн эзэмшлийн 110/35/10 кВ, 110/10 кВ, 35/10 кВ, 35/6 кВ, 35/0.4 кВ-ийн 44, хэрэглэгчийн эзэмшлийн 66, нийт 110 дэд станц, 15/0.4 кВ, 10/0.4 кВ, 6/0.4 кВ-ын компанийн болон хэрэглэгчийн эзэмшлийн 994 хаалттай трансформаторын хуваарилах байгууламжууд, агаарын дэд станцуудад хяналт хэмжилтийг явуулав. Хэмжилтэд 0.4 кВ, 6 кВ, 10 кВ-ын амперклевц, вольтметр, щитны хэмжүүрүүд, ВАФ-85, тестер, микропроцессорын реле, ЦЭХ-ний ухаалаг тоолууруудын HES системийн өгөгдлүүдийг ашигласан.


Хүснэгт 15. Өвлийн их ачааллын хэмжилт (дэд станцуудын тоо)

Д/д	Салбар	Компанийн эзэмшлийн дэд станцууд		Хэрэглэгчийн эзэмшлийн дэд станцууд	
		35-110 кВ	6-15 кВ	35 кВ	6-15 кВ
1	2	3	4	5	6
1	Дорноговь	8	144	6	86
2	Дундговь	13	76	7	48
3	Хэнтий	9	109	13	117
4	Багануур	6	99	6	119
5	Говьсүмбэр	8	73	34	123
БҮГД		44	495	66	493

Хэмжилтийн үр дүн 35 кВ-ын түвшинд:

Хэмжилт хийсэн цэгүүдэд хэмжилтийн дүн, параметруудийг эмхэтгэж, манай компанийн түгээх сүлжээгээр урсан өнгөрсөн чадлыг хэмжилт хийсэн өдрөөр буюу 2022 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн хэмжилт хийгдсэн цаг тус бүрээр хүснэгт 2 болон график 1-ээр харуулбал:

Үзүүлэлт	2021 03 цаг	2022 04 цаг	2021 11 цаг	2022 11 цаг	2021 18 цаг	2022 19 цаг	2021 23 цаг	2022 23 цаг
1	2	3	4	5	6	7	8	9
Чадал /кВт/	64884.1	65343.8	81410.9	82797.7	74624.6	76863.0	63410.3	83487.3




Хэмжилтийн дүн (график)

2021, 2022 оны чадлын урсгалын харьцуулалтын зөрүү	0.459 МВт	1.38 МВт	2.238 МВт	20.0 МВт
		0.7 % өссөн	1,67 % өссөн	2.91 % өссөн

Компанийн түгээх болон нам хүчдэлийн хуваарилах сүлжээний хоногийн ачааллын графикаас урсах чадлын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэмжилт хийсэн цагуудад 0.7 – 24 % буюу 0.459 – 20 МВт чадлаар өссөн дүнтэй байна.

1. Компанийн харьяа салбаруудын цахилгаан дамжуулах шугам, дэд станц бүрийн ачааллын хэмжилтийг өмнөх оны мөн үетэй харьцуулсныг зургаар харуулав.




Дорноговь ЦТС салбарын дэд станцууд (график)


Дорноговь ЦТС салбарын 8 дэд станцаас 2 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс 112.4 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 3 дэд станцын ачаалал 262 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй, 110/10 кВ Чөлөөт бүс дэд станцад ачаалалгүй байна. 35/0.4 кВ Тойг, 35/0.4 кВ Баян дэд станцууд тасархай байсан.

10 кВ РП-1, 2 хуваарилах байгууламжууд өмнөх оны мөн үеэс 649 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй байна.

Тус салбарын хэмжилтэд хамрагдсан 35 кВ-ын 8 дэд станцаас ачаалалтай 5 дэд станцын хувьд өмнөх оны мөн үеэс ачааллын хэмжээ 148 кВт чадлаар буурсан, ачаалалтай 5 дэд станцын нийт суурилагдсан хүчин чадал 16330 кВА байгаагаас 29.1 % буюу 4762 кВА чадлыг ашиглаж байна.




Дундговь ЦТС салбарын 35 кВ хүчдэлийн түвшний 13 дэд станцаас 4 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс 224 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 2 дэд станц 142 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй, Худгийн 1 дэд станц засварт, 1 дэд станц тасархай, 4 дэд станцын ачаалал тогтмол байна. Тус салбарын хэмжилтэд хамрагдсан 35 кВ-ын 13 дэд станцын хувьд өмнөх оны мөн үеэс 91 кВт чадлаар өссөн, нийт трансформаторуудын суурилагдсан хүчин чадал **13310** кВА байгаагаас 45.13 % буюу 6002 кВт чадлыг ЦЭХ хэрэглэгчдэд түгээж байна.



Хэнтий ЦТС салбарын дэд станцууд (график)


Хэнтий ЦТС салбарын 35 кВ-ын хүчдэлийн түвшний 9 дэд станцаас 5 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс 624 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 3 дэд станц 408 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй байна. 35/6 кВ Бэрх-Уул дэд станц тасархай. Тус салбарын хэмжилтэд хамрагдсан 35 кВ-ын дэд станцуудын хувьд өмнөх оны мөн үеэс ачааллын хэмжээ 566 кВт чадлын бууралттай, нийт хүчний трансформаторуудын суурилагдсан хүчин чадал 26500 байгаагаас 15.7 % буюу 4227 кВт чадлыг ЦЭХ хэрэглэгчдэд түгээж байна.



Багануур ЦТС салбарын дэд станцууд (график)

Багануур ЦТС салбарын 6 дэд станцаас 4 дэд станцын ачаалал өмнөх оны мөн үеэс 49 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй, 2 дэд станц 112 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй байна. Тус салбарын хэмжилтэд хамрагдсан 6 дэд станцын хувьд өмнөх оны мөн үеэс ачааллын хэмжээ 65 кВт чадлаар буурсан үзүүлэлттэй байна. Тус салбарын эзэмшлийн 35 кВ-ын 6 дэд станцуудын нийлбэр суурилагдсан хүчин чадал 9600 кВА чадал байгаагаас 14.3 % буюу 1381 кВт чадлыг ЦЭХ хэрэглэгчдэд түгээж байна.

6 кВ-ын РП-1, РП-2, РП-3, РУ-6 хуваарилах байгууламжууд өмнөх оны мөн үеэс ачааллын хэмжээ 1745 кВт чадлаар өссөн үзүүлэлттэй байна.



Говьсүмбэр ЦТС салбарын дэд станцууд

